



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/98/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn Аудитор: М.Ганбаатар Утас: 261628 Цахим хаяг: ganbaatar.m@audit.gov.mn Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	15
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	18
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	25
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	30
4.1 Ерөнхий зүйл	30
4.2 Материаллаг байдал.....	30
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	30
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	30
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	30
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	31
Албан шаардлага	31
Зөвлөмж.....	33
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	37
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	38
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	39
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил	39
5.1.1 Албан шаардлага	39
5.1.2 Зөвлөмж.....	40
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	43

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУИХ	Монгол Улсын Их Хурал
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
САГ	Санхүүгийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ЭТТ	Эрдэнэс тавантолгой
DAF	Delivered at Place
FCA	Free Carrier Arrangement



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЦЭРЭНСАМБУУ ТАНАА

2026. 03. 16 № 682
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон 120,249.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц байна. Тухайлбал:

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар тогтоолоор төрд ногдох ногдол ашгийн орлогоос Эрдэнэс Тавантолгой ХК, “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний нэгдэлд хамаарах, төрийн өмчийн оролцоотой бусад аж ахуйн нэгжүүдийн хооронд үүссэн өр, авлагыг суутган тооцохоор зохицуулсан боловч уг зохицуулалт хэрэгжээгүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу 2022–2023 оны төрд ногдох ногдол ашгийн 3,305,196.7 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл бүртгэлтэй;
- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2019 онд байгуулсан “Тавантолгой–Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн гэрээ” болон хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийн дагуу төслийн санхүүжилтийг хувьцаанд хөрвүүлэхээр зохицуулсан боловч нийт 3,283,903.7 сая төгрөгийн санхүүжилтээс 1,346,716.6 сая

төгрөгийг хувьцаанд хөрвүүлж, үлдсэн 1,937,187.0 сая төгрөгийг хөрвүүлээгүй, гэрээний заалт бүрэн хэрэгжээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.10, 46.13, 84 дүгээр зүйлийн 84.4.2 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

1. 2025 онд Засгийн газраас тогтоосон онцгой дэглэмийн нөлөө

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрээр Эрдэнэс Тавантолгой ХК-д гурван сарын хугацаатай онцгой дэглэм тогтоож, Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн багийг томилон ажиллуулсан.

Онцгой дэглэмийн хүрээнд нүүрс тээвэрлэлтийг эрчимжүүлэх, хил нэвтрүүлэх үйл ажиллагаа болон салбар дундын уялдааг сайжруулах, гадаад валютын орлогын урсгал, нөөцийг нэмэгдүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, компанийн үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх чиглэлээр цогц арга хэмжээ авч ажилласан байна.

2. Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын стратегийн ач холбогдол

Тайлант онд Монгол Улс болон БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 310 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Гашуунсухайт–Ганцмод чиглэлийн хил дамнасан төмөр замын төслийг хэрэгжүүлэх, бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор “Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн гэрээ”, “Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн эргэн төлөлтийн гэрээ”-г тус тус байгуулсан байна.

Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын төсөл хэрэгжсэнээр өргөн царигийн 30.0 сая тонн, нарийн царигийн 10.0 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадал бүхий төмөр замын дэд бүтэц бий болж, үүний үр дүнд Монгол улс болон БНХАУ-ын худалдааны эргэлт, бүс нутгийн хамтын ажиллагааг ахиулах, экспортыг нэмэгдүүлэх, Монгол Улсын өмнөд бүсийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, төмөр замын дагуух аж үйлдвэржилтийг бий болгох боломж бий болж байна.

3. Тавантолгой дулааны цахилгаан станцын тендер хүчингүй болсон байдал

Түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр хэрэгжих, нийт 597.08 сая ам.долларын төсөвт өртөг бүхий Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцын эхний ээлжийн 300 МВт-ын хүчин чадлын гүйцэтгэгч болон санхүүжилтийн эх үүсвэрийг сонгон шалгаруулах тендерийг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зарласан

Тус тендертэй холбоотойгоор оролцогч этгээдээс шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу Монгол Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим 2024 оны хяналтын шатны шүүх хуралдаанаар тендерийг хүчингүй болгох шийдвэр гаргасан байна. Үүний улмаас төслийн хэрэгжилтийн явц, санхүүжилтийн бүтэц, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тодорхойгүй байдал үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

1. Нүүрсний борлуулалтын орлого, индексжүүлсэн үнэ болон борлуулалтын гэрээний нөхцөл

Компанийн 2025 онд хэрэгжүүлсэн нүүрсний борлуулалтын үйл ажиллагаа нь олон улсын зах зээл дэх үнийн хэлбэлзэл, борлуулалтын гэрээний олон төрөл (урт хугацааны, оффтэйк болон биржийн арилжаа), олон улсын худалдааны FCA болон DAP нөхцөл, мөн үнэ тогтоолтод ашиглагддаг олон улсын индексүүдийн нөлөөн дор хэрэгжсэн байна.

Тайлант хугацаанд компани нийт 27.6 сая тонн нүүрс борлуулж, 1,711.0 сая ам.долларын орлого олсон бөгөөд үүнд хатуу коксжих нүүрс 17.9 сая тонн, 1/3 коксжих нүүрс 5.7 сая тонн, эрчим хүчний нүүрс 3.0 сая тонн, баяжуулсан нүүрс 1.0 сая тонн тус тус багтсан байна.

Борлуулалтын үнэ тогтоолтод CR China Coking Coal Index, Primary Coking Avg, Shanxi Liulin, Platts HCC 64 Mid Vol, MB Coal Index CFR Jingtang зэрэг олон улсын нүүрсний индексүүдийг ашигладаг бөгөөд эдгээр индексүүд улирал бүр шинэчлэгддэг онцлогтой. Тайлант хугацаанд нүүрсний зах зээлийн үнэ буурч, зарим төрлийн нүүрсний үнэ 53 хүртэл хувиар буурсан нь борлуулалтын үнэ, орлогын хэмжээнд нөлөөлсөн байна.

Мөн тайлант онд Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан 151 удаагийн хэлцлээр нийт 12.5 сая тонн нүүрсийг 804.3 сая ам.долларын дүнгээр арилжаалснаас 8.5 сая тонн 624.4 сая ам.долларын үнэтэй нүүрсийг худалдан авагчдад нийлүүлсэн нь компанийн борлуулалтын үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулсан байна.

2. Томоохон хөрөнгө оруулалтын төслүүд

Компанийн 2025 оны үйл ажиллагаанд экспортын дэд бүтэц, боловсруулах үйлдвэрлэл болон эрчим хүчтэй холбоотой стратегийн ач холбогдол бүхий томоохон хөрөнгө оруулалтын төслүүд хэрэгжиж байна. Үүнд:

- Нүүрс баяжуулах үйлдвэр – жилд 10.0 сая тонн хүчин чадалтай уг үйлдвэр 2025 онд ашиглалтад орж, тайлант онд 1.2 сая тонн нүүрс баяжуулсан .
- Нүүрс тээврийн конвейрийн систем – 2025 оны эцэст 95% гүйцэтгэлтэй, нийт 244,014.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд 2026 оны эхний улиралд бүрэн хүчин чадлаар ажиллаж эхлэх төлөвтэй байна.
- Газрын тос дамжуулах хоолой – 90.3% гүйцэтгэлтэй, нийт 388.1 сая ам.долларын өртөгтэй, үүнээс нийт 266.0 сая ам.доллартой дүйцэх 3.5 сая тонн нүүрсийг нийлүүлээд байна.
- Гашуунсухайт–Ганцмод хил дамнасан төмөр зам – 9% гүйцэтгэлтэй, 254,657.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

3. Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийн үнэлгээ

Тайлант онд нүүрсний олон улсын зах зээлийн үнэ 2025 оны эхэн үеэс дунджаар 20 хувь, 2024 оны эхэн үетэй харьцуулахад 53 хувиар огцом буурсантай холбоотойгоор

бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг үнэлэхэд эрсдэл үүссэн. Коксжих нүүрсний үнэ улирлын дундаж нь 123–151 ам.доллар/тонн, 1/3 коксжих нүүрсний үнэ 67–72 ам.доллар/тонн, эрчим хүчний нүүрсний үнэ 34–35 ам.доллар/тонн түвшинд хүрч буурсан нь бараа материалын үнэлгээнд нөлөөлөх нөхцөл болсон.

Бусад асуудал

Тайлан онд компанийн үйл ажиллагаанд дараах шинж чанартай онцгой нөхцөл байдал, эрсдэлийн хүчин зүйлс ажиглагдсан. Үүнд:

1. Дотоод хяналтын хэрэгжилтийн үр нөлөө

Компанийн хэмжээнд нийт 39 хяналт шалгалт, 25 эрсдэлийн үнэлгээ хийж, өгсөн 256 зөвлөмжийн 87 хувь нь хэрэгжсэн боловч зарим нэгжид хяналтын хэрэгжилтийн үр нөлөө хангалтгүй, давтагдсан эрсдэл ажиглагдсан. Тухайлбал, эрсдэлийн үнэлгээг улирал тутам шинэчлэхгүйгээс “өндөр” ангиллын эрсдэлүүд хугацаандаа буураагүй, мөн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн баримтжуулалт, нотлох баримтын бүрдүүлэлт дутуу тохиолдол гарсан.

2. Дээд байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Компанид хамаарах 74 заалтаас 83.6 хувь нь хэрэгжсэн боловч 7 заалт хойшлогдсон. Тухайлбал, Засгийн газрын зарим тогтоолын хэрэгжилт хугацаандаа хангагдаагүйгээс тайлагнал, баримтжуулалтын үйл явц удааширч, ихэвчлэн стратегийн хөрөнгө оруулалт, дэд бүтцийн төслүүдтэй холбоотой шийдвэрүүдийн хэрэгжилт саатсан.

3. Гэрээ, хууль эрх зүйн маргаан

Гэрээний 28, хөдөлмөрийн 23 маргаан бүртгэгдсэн нь гэрээний гүйцэтгэлийн хяналт болон хүний нөөцийн баримтжуулалтын сул талыг илтгэнэ. Тухайлбал, гэрээ дүгнэх акт, гүйцэтгэлийн баримт дутуу бүрдсэн, хөдөлмөрийн маргаан нь сахилгын шийтгэл, ажилтны шилжилт хөдөлгөөн, ажлын байрны тодорхойлолттой холбоотой байсан.

4. Аюулгүй ажиллагаа ба ослын эрсдэл

Тайлант онд 376 осол, 908 зөрчил бүртгэгдэж, 13,855 хүн сургалтад хамрагдсан. Тухайлбал, бие хамгаалах хэрэгсэл хэрэглэхгүй байх, зөвшөөрөлгүй бүсэд нэвтрэх зэрэг давтагдсан зөрчил тогтмол ажиглагдсан бөгөөд зарим нэгжид шалтгаан-үр дагаврын шинжилгээ болон сайжруулах арга хэмжээ хангалтгүй байсан.

5. Байгаль орчны эрсдэл

Уурхайн бүсэд PM2.5, PM10 тоосжилт стандарт хэмжээнээс 2–3 дахин давж, усны хэрэглээ өндөр хэвээр байна. Тухайлбал, тоос дарах арга хэмжээний үр нөлөө хангалтгүй, мөн Цанхийн уурхай, нүүрс баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээ өндөр байгаа нь усны нөөцийн болон нөхөн сэргээлтийн зардлын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Дээрх асуудал нь аудитын дүгнэлтэд шууд нөлөөлөхгүй боловч цаашид тайлангийн хэрэглэгчид зайлшгүй анхаарах шаардлагатай. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,431,077,104,112.02	541,726,359,601.22
1.1.2	Дансны авлага	718,079,593,745.89	718,806,920,111.64
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	1,215,648,808.41	7,378,097.62
1.1.4	Бусад авлага	258,854,421,891.37	311,797,218,616.88
1.1.6	Бараа материал	506,601,074,821.23	675,165,497,337.14
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,821,204,095,428.11	2,046,126,742,085.16
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,737,031,938,807.03	4,293,630,115,849.66
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,126,210,634,486.61	2,755,105,923,555.15
1.2.2	Биет бус хөрөнгө	11,087,027,404,581.30	11,041,481,706,082.40
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,346,763,751,000.00	2,040,526,866,000.00
1.2.6	Бусад эргэлтийн бус хөрөнгө	3,752,946,810,979.70	3,554,366,629,521.46
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	18,312,948,601,047.60	19,391,481,125,159.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	24,049,980,539,854.70	23,685,111,241,008.70
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	204,342,698,318.92	282,313,301,556.78
2.1.1.2	Цалингийн өглөг	10,139,502,388.68	19,433,756,492.63
2.1.1.3	Татварын өр	456,685,034,816.66	79,162,813,439.36
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	3,305,196,752,456.20	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,330,234,984,371.79	1,689,357,856,128.22
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	362,330,561,858.78	408,611,533,146.03
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,668,929,534,211.03	2,478,879,260,763.02
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/ УХ	165,372,780,665.81	50,391,422,249.05
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	38,328,000,367.01	42,552,547,476.62
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	762,988,699,600.00	6,448,048,203,964.41
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	966,689,480,632.82	6,540,992,173,690.08
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,635,619,014,843.85	9,019,871,434,453.10
2.3	Эздийн өмч		
2.3.3	Өмч: - хувьцаат	11,196,000,000,000.00	11,196,000,000,000.00
2.3.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	75,036,228,890.00	75,036,228,890.00
2.3.5	Эздийн өмчийн бусад хэсэг		(1,743,287,513.28)
2.3.6	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	6,143,325,296,120.83	3,395,946,865,178.90
2.3.5	Эздийн өмчийн дүн	17,414,361,525,010.80	14,665,239,806,555.60
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	24,049,980,539,854.70	23,685,111,241,008.70

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	10,250,718,799,556.90	6,046,288,547,129.61
2	Борлуулалтын өртөг	1,917,458,166,356.27	3,256,151,338,866.26
3	Нийт ашиг(алдагдал)	8,333,260,633,200.68	2,790,137,208,263.35
4	Түрээсийн орлого	259,268,727.29	279,159,636.37
5	Хүүний орлого	112,522,187,700.56	95,389,680,396.29
8	Бусад орлого	207,450,366,672.07	563,279,764,482.42
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,186,913,032,368.92	1,301,404,736,248.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	146,995,364,678.93	115,005,813,999.16
11	Санхүүгийн зардал	34,147,708,080.51	4,509,720,539.91
12	Бусад зардал	253,603,330,041.24	584,363,167,986.70
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(2,147,220,985.81)	44,681,652,651.46
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(150,274,485.37)	(145,611,856.37)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6,029,535,525,659.82	1,488,338,414,799.75
19	Орлогын татварын зардал	1,501,128,734,420.66	364,529,025,267.15
20	Татварын дараах ашиг (алдагдал)	4,528,406,791,239.16	1,123,809,389,532.60
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	4,528,406,791,239.16	1,123,809,389,532.60
25	Орлогын нийт дүн	10,570,950,622,656.90	6,749,918,804,296.15

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ ний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	-	-	5,891,176,619,623.40	17,087,176,619,623.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	220,141,885,258.27	220,141,885,258.27
3	Залруулсан үлдэгдэл	11,196,000,000,000.00	-	-	6,111,318,504,881.67	17,307,318,504,881.70
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	4,528,406,791,239.16	4,528,406,791,239.16
6	Өмчид гарсан өөрчлөлт (дахин үнэлгээ)	-	75,036,228,890.00	-	-	75,036,228,890.00
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	(4,496,400,000,000.00)	(4,496,400,000,000.00)
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	75,036,228,890.00	-	6,143,325,296,120.83	17,414,361,525,010.80
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	46,812,179,525.47	46,812,179,525.47
11	Залруулсан үлдэгдэл	11,196,000,000,000.00	75,036,228,890.00	-	6,190,137,475,646.30	17,461,173,704,536.30
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,123,809,389,532.60	1,123,809,389,532.60
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(1,743,287,513.28)	-	(1,743,287,513.28)
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(3,918,000,000,000.00)	(3,918,000,000,000.00)
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	75,036,228,890.00	(1,743,287,513.28)	3,395,946,865,178.90	14,665,239,806,555.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,643,858,236,406.18	6,075,534,671,831.85
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	9,625,078,878,246.54	6,064,371,829,851.21
1.1.6	Бусад мөнгөн орлого	18,779,358,159.64	11,162,841,980.64
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,537,208,393,474.58	5,602,078,822,859.89
1.2.1	Ажиллагчдад төлсөн	157,891,643,856.25	303,011,366,794.46
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	39,100,000,000.00	70,046,021,129.40
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,751,804,934,934.79	3,025,739,069,041.97
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	60,505,207.08	63,979,134.15
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	96,702,169,358.62	246,324,856,576.04
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	29,998,394,230.81	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,413,777,085,959.64	1,587,888,863,246.90
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,954,555,741.01	2,639,513,444.20
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,045,919,104,186.38	366,365,153,492.77
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,106,649,842,931.60	473,455,848,971.96
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	43,804,316,047.23	16,758,508,995.77
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	177,703,235.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	43,804,316,047.23	16,580,805,760.77
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,537,280,431,665.75	1,106,676,768,073.20
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	224,486,284,821.05	159,951,063,226.85
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	522,246,769.50	1,154,872,287.50
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	1,312,271,900,075.20	945,570,832,558.85
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,493,476,115,618.52)	(1,089,918,259,077.43)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,741,092,447,572.17	277,789,256,469.13
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	306,875,700,000.00	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	1,434,216,747,572.17	277,789,256,469.13
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,741,092,447,572.17)	(277,789,256,469.13)
4	Валютын ханшийн зөрүү	(5,197,096,929.23)	4,900,922,063.80
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(133,115,817,188.32)	(899,350,744,510.80)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,564,192,921,300.34	1,431,077,104,112.02
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,431,077,104,112.02	541,726,359,601.22

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилгот төвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он			Харьцуулалт		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
1	Уулын ажлын төлөвлөгөө								
	Уулын цул	м.м3	155,452	201,931	203,116	47,664	131%	1,186	101%
	Хөрс хуулалт	м.м3	133,703	180,502	181,540	47,837	136%	1,039	101%
	Нүүрс олборлолт	м.тн	30,449	30,000	30,206	(242)	99%	206	101%
	Хөрс хуулалтын коэффициент	м3/тн	4.4	6.0	6.0	2	137%	(0.0)	100%
2	Борлуулалтын төлөвлөгөө								
	Борлуулах нүүрсний хэмжээ	м.тн	29,639	30,000	27,622	(2,017)	93%	(2,378)	92%
	Үүнээс: Уурхайн ам нөхцөл	м.тн	18,277	19,454	19,081	803	104%	(374)	98%
	Хил хүрээж өгөх нөхцөл	м.тн	11,362	10,546	8,542	(2,820)	75%	(2,004)	81%
	Борлуулалтын орлого	м.\$	3,019,298.5	1,859,336.1	1,711,014.6	(1,308,283.9)	57%	(148,321.5)	92%
	Борлуулах нүүрсний жинлэсэн дундаж үнэ	\$/тн	101.9	62.0	61.9	(40)	61%	(0.0)	100%
	Нийт орлого	м.төг	10,570,950,622.7	7,043,554,673.1	6,749,918,804.3	(3,821,031,818.4)	64%	(293,635,868.8)	96%
3	Үүнээс: Нүүрс борлуулалтын орлого	м.төг	10,250,718,799.6	6,693,610,010.9	6,046,288,547.1	(4,204,430,252.4)	59%	(647,321,463.8)	90%
	Нийт зардал	м.төг	4,541,415,097.0	4,903,160,145.6	5,261,580,389.5	720,165,292.5	116%	358,420,243.9	107%
	Үйл ажиллагааны зардал	м.төг	4,285,514,271.5	4,798,643,737.0	4,677,071,609.7	391,557,338.2	109%	(121,572,127.4)	97%
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м.төг	1,917,458,166.4	2,528,788,004.5	3,256,151,338.9	1,338,693,172.5	170%	727,363,334.4	129%
	Борлуулалтын зардал (АМНАТ, гаалийн хураамж, хүргэж өгөх тээвэр, логистикийн зардал багтсан)	м.төг	2,186,913,032.4	2,113,667,598.3	1,301,404,736.2	(885,508,296.1)	60%	(812,262,862.0)	62%
4	Ерөнхий ба удирдлагын зардал	м.төг	146,995,364.7	148,590,444.2	115,005,814.0	(31,989,550.7)	78%	(33,584,630.2)	77%
	Хайгуул үнэлгээ, судалгаа хөржүүлтийн зардал	м.төг	-	7,597,690.1	-	-	-	(7,597,690.1)	-
	Санхүүгийн зардал	м.төг	34,147,708.1	-	4,509,720.5	(29,637,987.5)	13%	4,509,720.5	0%
	Үйл ажиллагааны бус зардал	м.төг	12,961,105.6	104,516,408.6	43,855,049.6	30,893,944.0	338%	(60,661,359.0)	42%
	Нийгмийн хариуцлагын зардал	м.төг	11,307,381.6	99,852,502.0	41,264,595.1	29,957,213.5	365%	(58,587,906.9)	41%
	Үйл ажиллагааны бус зардал	м.төг	1,653,724.0	4,663,906.6	2,590,454.6	936,730.5	157%	(2,073,452.0)	56%
	Бусад зардал	м.төг	242,939,719.9	-	540,653,730.2	297,714,010.3	223%	540,653,730.2	
	Бараа материалын үнийн бууралт	м.төг	194,257.5	-	6,728,165.8	6,533,908.3	3464%	6,728,165.8	
	Урт хугацаат авлагын үнэ цэнийн бууралт	м.төг	183,553.0	-	2,619,625.4	2,436,072.4	1427%	2,619,625.4	
	Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн үнэлгээний тохируулгын хэрэгжээгүй гарз	м.төг	190,855,424.2	-	8,410,376.8	(182,445,047.4)	4%	8,410,376.8	
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хуугийн	м.төг	42,480,579.7	-	517,762,749.6	475,282,169.9	1219%	517,762,749.6		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Эрдэнэс Тавантолгой ХК нь алсын хараагаа “Бид дэвшилтэт технологи, ур чадварт тулгуурлан үнэ цэнийг бүтээж Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулсан тэргүүлэгч компани байна”, эрхэм зорилгоо “Бид тогтвортой, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадвартай, сайн засаглал бүхий компани байна” гэж тодорхойлсон байна.

Эрдэнэс Тавантолгой ХК нь Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 272 дугаар тогтоолын дагуу байгуулагдаж, 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн уул уурхайн салбарын үндэсний хэмжээний томоохон компани юм. Компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Засгийн газрын 2021 оны 367 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК хэрэгжүүлж байгаа бөгөөд компанийн гаргасан нийт 12,000.0 сая ширхэг энгийн хувьцааны 73.5 хувийг эзэмшдэг, үлдсэн хувьцааг Монгол Улсын иргэд болон дотоодын аж ахуйн нэгжүүд эзэмшиж байна.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь Тавантолгойн бүлэг ордын нүүрсний нөөцийг түшиглэн олборлолт, баяжуулалт, борлуулалт, бүтээгдэхүүний тээвэр, логистикийн үйлчилгээ үзүүлэх, мөн ордыг түшиглэсэн дэд бүтэц, боловсруулах үйлдвэрлэлийн төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Тавантолгойн бүлэг орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших 71.7 мянган га талбай бүхий стратегийн ач холбогдолтой орд бөгөөд компани уг ордын 68.5 мянган га талбайд хамаарах 8 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн хэрэгжүүлсэн геологи, хайгуулын ажлын үр дүнд ордын нүүрсний нөөц 29.0 хувиар нэмэгдэж, нийт нөөц 8.1 тэрбум тонн болж 2024 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр баталгаажсан. Нөөцийн энэхүү өсөлт нь компанийн олборлолт, дэд бүтэц болон борлуулалтын дунд болон урт хугацааны төлөвлөлтөд чухал нөлөө үзүүлж байна.

Компанийн дүрмийн дагуу хайгуул, олборлолт, баяжуулалт, нүүрс тээвэрлэлтийн болон гаалийн хяналтын бүсийн үйлчилгээ, барилгын материалын түүхий эдийн үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэр байгуулах, судалгаа-шинжилгээний лабораторийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхтэй. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 8 дугаар тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 2,244 байхаар шинэчлэн баталсан бөгөөд тайлант хугацаанд батлагдсан бүтэц, орон тооны дагуу нийт 1,766 ажилтан ажилласнаас 91.2 хувь нь уурхайн салбарт, 8.8 хувь нь төв захиргаанд харьяалагдаж байна.

Компанийн урт хугацаат хөрөнгө оруулалтын багцад экспортын дэд бүтэц, эрчим хүч болон нүүрс боловсруулахтай холбоотой охин, хараат компаниуд багтдаг. Үүнд “Гашуунсухайт авто зам” ХХК, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК, “Тавантолгой түлш” ХХК зэрэг байгууллагууд багтах бөгөөд эдгээр нь компанийн олборлолтоос экспорт хүртэлх дэд бүтэц, логистикийн сүлжээ болон холбогдох төслүүдтэй уялдсан стратегийн ач холбогдолтой хөрөнгө оруулалтын нэгжүүд байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Эрдэнэс Тавантолгой ХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Газрын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох МУИХ, МУЗГ-ын тогтоол, компанийн удирдлагаас баталсан дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд тус компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь уул уурхайн бүтээгдэхүүний нөөц ашигласны төлбөрийн бодлого, баяжуулалт боловсруулалтын түвшнээс хамаарах татварын тогтолцоог шинэчилж, биржийн үнээр төлбөр тооцох эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлсэн байна. Түүнчлэн баяжуулалтын тусгай зөвшөөрлийн ангилал, эрх үүрэг, үүсмэл ордын ашиглалтын журмыг тодорхой

- болгосон нь компанийн татварын суурь, баяжуулалтын үйл ажиллагаа, бүтээгдэхүүний үнэлгээ, борлуулалтын бодлогод бодит нөлөө үзүүлсэн;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж, татварын хөнгөлөлт, татварын босго, элэгдэл тооцох журам болон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын татварын зохицуулалт шинэчлэгдсэн;
 - Төсвийн тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгаж, төсвийн сахилга бат, дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байна. Тухайлбал: Төсвийг зохисгүй удирдсанаас авлага, өглөг үүсгэсэн төсвийн захирагчид хариуцлага тооцох эрх зүйн үндсийг тодорхой болгож, дунд хугацааны төсвийн мэдээлэлд хараат бус хяналтыг нэмэгдүүлсэн, мөн төсвийн баримт бичгийн хугацааг богиносгон зохион байгуулалтын сахилга батыг сайжруулсан. Түүнчлэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс үл хамааран төсвийн бодлогын залгамж чанарыг хадгалах, эрх мэдлийн давхардлыг арилгах зохицуулалтыг тусгаснаар төсвийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн удирдлагын хяналтын орчныг бэхжүүлсэн;
 - Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төрийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг хязгаарлах, хэмнэлтийг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн. Үүнд, зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүдэд нэмэлт хөлс, урамшуулал олгохыг хориглож, байгууллагын төсвөөр уралдаан, арга хэмжээ зохион байгуулах, семинар, хурал, томилолттой холбоотой зардлыг бууруулах, мөн албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулах замаар бичиг хэргийн болон шуудангийн зардлыг хэмнэх зохицуулалтыг хуульчилсан;
 - Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь дунд хугацааны төсвийн хүрээ, нэгдсэн төсвийн тэнцвэржилт, төсвийн тодотголын зохицуулалтыг бодит нөхцөлд нийцүүлэн уян хатан болгох, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс шалтгаалан төсвийн тогтвортой байдлын шалгуур зөрчигдөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн. Мөн төсвийн тогтвортой байдлын үзүүлэлт, тайлагналтай холбоотой зарим давхардсан заалтыг цэгцэлж, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгосон.

Тайлант хугацаанд компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтын тогтолцоог аудитын төлөвлөлт болон гүйцэтгэлийн үе шатанд үнэлэхэд хяналтын зарим ажиллагаа тогтмол бөгөөд үр нөлөөтэй хэрэгжихгүй байгаа нь ажиглагдсан.

Компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь Хяналт шалгалтын хэлтэс, Эрсдэлийн удирдлагын хэлтэс, Салбарын дотоод хяналтын хэлтэс гэсэн бүтэцтэй, нийт 19 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгжийн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, компанийн 2023 оны А/137 дугаар тушаалаар баталсан “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”, А/92 дугаар тушаалаар баталсан “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант онд Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн баталсан жилийн төлөвлөгөөний хүрээнд 5 үндсэн чиглэлээр нийт 43 ажлыг хэрэгжүүлж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, стандартын тохирлын үнэлгээ, хяналт-шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэсэн байна. Үүний хүрээнд 9 хяналт шалгалтын тайлан, 51 дүгнэлт, 14 хяналтын хуудас, 3 мэдэгдэх хуудас, 16 саналын хуудас, 8 хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, 10 нэгжид стандартын тохирлын үнэлгээ, 13 эрсдэлийн үнэлгээний тайлан боловсруулж, нийт 250 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай байна.

Аудитын үнэлгээгээр дотоод хяналтын газрын гүйцэтгэлийн тоон үзүүлэлт хангалттай байгаа боловч компанийн үйл ажиллагааны өндөр эрсдэлтэй чиглэлүүдэд суурилсан системтэй хяналтыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх, эрсдэлийн үнэлгээг бодит мэдээлэлд тулгуурлан илүү нарийвчлан тодорхойлох, эрсдэлийн хариу арга хэмжээний хэрэгжилтийн мониторингийг тогтмолжуулах, мөн эрх зүйн нийцэл болон дотоод журмын хэрэгжилтийн хяналтын үр нөлөөг

нэмэгдүүлэх шаардлага хэвээр байна. Энэ нь компанийн дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх, эрсдэлийн удирдлагын үр ашигт байдлыг цаашид сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2020 онд PWC Audit Олон улсын аудитын компаниар гүйцэтгүүлж, компанийн гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/357 дугаар тушаалаар баталгаажуулсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын ерөнхий шаардлагад нийцүүлэн боловсруулагдсан байна. Гэвч уул уурхайн салбарын үйл ажиллагааны онцлогтой холбоотой зарим ажил гүйлгээ, дансны бүртгэл, үнэлгээ, тайлагналын бодлогыг илүү нарийвчлан тодорхойлох, хэрэгжилтийн аргачлал, хариуцлагын зохицуулалтыг тодорхой болгох шаардлага байна. Тухайлбал:

1. Уурхай хаалтын болон нөхөн сэргээлтийн үүргийн тооцоолол, шинэчлэл

Бодлогын баримт бичгийн Гуравдугаар бүлэг, 1 дүгээр хэсэг “Уул уурхайн бүртгэл”, 5 дугаар үе шат “Уурхайг хаах” болон СТОУСТХ 1 “Хөрөнгийг ашиглалтаас хасах, нөхөн сэргээх болон түүнтэй ижил төстэй бусад өр төлбөрийн өөрчлөлт” хэсгүүдэд уурхай хаалтын болон нөхөн сэргээлтийн үүргийн нөөцийг хүлээн зөвшөөрөх, холбогдох зардлыг капиталжуулах ерөнхий зарчмыг тусгасан байна. Гэвч уг үүргийн хэмжээг тодорхойлохдоо ашиглах үндсэн таамаглалууд болох хөнгөлөлтийн хувь хэмжээ, инфляцын таамаглал, нөхөн сэргээлтийн технологийн болон нэгж зардлын тооцооллыг хэрхэн тодорхойлох, ямар байгууллагын дүгнэлтэд үндэслэх, хэн баталгаажуулах, мөн ямар давтамжтайгаар шинэчлэх талаар бодлогын түвшинд тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна. Эдгээр таамаглал нь санхүүгийн тайлангийн өр төлбөрийн үнэлгээ болон холбогдох хөрөнгийн дансанд материаллаг нөлөө үзүүлэх боломжтой тул тооцооллын аргачлал, баталгаажуулах болон шинэчлэх журмыг бодлогын баримт бичигт тодорхой тусгах шаардлагатай байна.

2. Харилцагчдын урамшуулал, хөнгөлөлтийн бүртгэл

Хоёрдугаар бүлэг, 11 дүгээр хэсэг “Харилцагчидтай байгуулсан гэрээний орлого” (СТОУС 15) хэсэгт ажил гүйлгээний үнийг тодорхойлох ерөнхий зарчмыг тусгасан боловч нүүрсний борлуулалтын гэрээнд нийтлэг тохиолддог эзлэхүүний хөнгөлөлт, чанарын хазайлтаас хамаарах урамшуулал болон торгуулийн нөхцөл зэрэг хувьсах төлбөрийг орлогод хэрхэн тусгах талаар тодорхой аргачлал тусгагдаагүй байна. Иймд хувьсах төлбөрийг тооцоолох аргачлал (жишээлбэл, хүлээгдэж буй үнийн дүнгийн арга эсвэл хамгийн магадлалтай үнийн арга), мөн тайлант хугацаанд орлогын үнэлгээнд хэрхэн тусгах талаар бодлогын түвшинд тодорхой зохицуулалт шаардлагатай байна.

3. Нүүрсний нөөц, баялгийн талаарх бодлогын зохицуулалт

Уул уурхайн үйл ажиллагаанд нүүрсний нөөц, баялгийн тооцоо нь элэгдэл, үнэ цэнийн бууралтын тест, уурхай хаалтын үүргийн тооцоолол зэрэг санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх суурь таамаглал болдог. Гэвч бодлогын баримт бичигт нөөц, баялгийг

тодорхойлох аргачлал, баталгаажуулах эрх бүхий этгээд, тайлангийн давтамж, шинэчлэлийн журам зэрэг асуудлыг тусгайлан тодорхойлоогүй байна.

4. Дайвар бүтээгдэхүүний бүртгэл (исэлдсэн нүүрс)

Хоёрдугаар бүлэг, 2 дугаар хэсэг “Бараа материал” (НББОУС 2) хэсэгт бараа материалын үнэлгээний ерөнхий зарчмыг тусгасан боловч дайвар бүтээгдэхүүний тодорхойлолт болон түүний бүртгэлийн бодлого тусгагдаагүй байна. Ялангуяа исэлдсэн нүүрс нь үндсэн бүтээгдэхүүнээс чанар, зах зээлийн үнээр ялгаатай тул түүнийг бараа материалын бүртгэлд хэрхэн ангилж, үнэлэх, борлуулалтын орлоготой уялдуулан бүртгэх талаар тодорхой бодлого боловсруулах шаардлагатай байна.

5. Үйл ажиллагааны сегментийн тайлагнал

Гуравдугаар бүлэг, 5 дугаар хэсэг “Үйл ажиллагааны хэсгүүд” (СТОУС 8) хэсэгт сегментийг тодорхойлох, тайлагнах ерөнхий шаардлагыг тусгасан боловч компанийн дотоод удирдлагын тайлагналын бүтэц, шийдвэр гаргах түвшинд ашиглагддаг мэдээлэлд тулгуурлан үйл ажиллагааны сегментүүдийг тодорхойлсон эсэх нь тодорхойгүй байна. Тухайлбал нүүрсний төрөл, үйлдвэрлэлийн шат дамжлага, эсвэл үйл ажиллагааны чиглэлээр сегментчилэх бодлогыг тодорхой тусгах шаардлагатай байна.

6. Дансны төлөвлөгөө

Бодлогын баримт бичигт нарийвчилсан дансны төлөвлөгөө тусгагдаагүй байна. Дансны төлөвлөгөө тодорхойгүй байгаа нөхцөлд зардлыг өртгийн төвүүдээр хуримтлуулах, хөрс хуулалтын хөрөнгийг тусгай дансанд бүртгэх, дайвар бүтээгдэхүүнийг ялган бүртгэх зэрэг бодлогын зохицуулалтыг практикт нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх эрсдэлтэй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрдэнэс Тавантолгой ХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тус компани нь “Севиллиа аудит” ХХК-тай ЭТТ-2025/559 дугаар бүхий “Бүтээгдэхүүний өртөг тооцох, хуваарилах аргачлал боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулж, зөвлөхийн тайлан, зөвлөмжийг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2025 оны А/460 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Уг өөрчлөлтөөр:

1. Өмнө нь хамсарсан бүтээгдэхүүний өртгийг тоо хэмжээний аргаар хуваарилдаг байсныг 2025 оноос борлуулалтын үнийн аргад шилжүүлж, бүтээгдэхүүний ангилал, чанар, зах зээлийн үнэ ялгаатай нөхцөлд өртгийг илүү оновчтой хуваарилах байдлаар өөрчилсөн.

2. Хойшлуулах хөрс хуулалтын хөрөнгийг тооцоолохдоо өмнө нь ТЭЗҮ-ийн тайлант хугацааны хөрс хуулалтын коэффициентийг ашиглаж байсан бол 2025 оноос ордын бүрэлдэхүүн хэсгийг ТЭЗҮ-ийн эхний 5 жилийн хугацаагаар тодорхойлон, тухайн хугацааны коэффициентод үндэслэн тооцоолох болсон.

3. Хөрсний дундаж өртгийг өмнө нь хөрс хуулалтын зардлыг гүйцэтгэлээрх хөрс хуулалт болон олборлолтын хэмжээнд харьцуулан тооцдог байсан бол 2025 оноос тайлант үеийн хөрс хуулалтын зардлыг гүйцэтгэлээрх уулын цулд харьцуулан тооцохоор өөрчилсөн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 364,869.3 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,431,077,104.1	541,726,359.6	(889,350,744.5)
Авлага	978,149,664.5	1,030,611,516.8	52,461,852.3
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,821,204,095.4	2,046,126,742.1	(775,077,353.3)
Бараа материал	506,601,074.8	675,165,497.3	168,564,422.5
Эргэлтийн бус хөрөнгө	18,312,948,601.0	19,391,481,125.2	1,078,532,524.2
Нийт хөрөнгө	24,049,980,539.8	23,685,111,241.0	(364,869,298.8)
Богино хугацаат өр төлбөр	5,668,929,534.2	2,478,879,260.8	(3,190,050,273.4)
Урт хугацаат өр төлбөр	966,689,480.6	6,540,992,173.7	5,574,302,693.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	17,414,361,525.0	14,665,239,806.5	(2,749,121,718.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	24,049,980,539.8	23,685,111,241.0	(364,869,298.8)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, урьдчилж төлсөн тооцоо, эргэлтийн бус хөрөнгө, богино болон урт хугацаат өр төлбөр, эздийн өмч дансад нөлөө бүхий өөрчлөлт орсон байна.

Мөнгөн хөрөнгийн данс

Тайлант оны санхүүгийн жилийн эцсийн байдлаарх компанийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 889,350.7 сая төгрөгөөр буурсан нь зах зээлийн таагүй нөхцөл байдал болон Засгийн газрын шийдвэрээр хэрэгжиж буй улсын хэмжээний стратегийн төслийн санхүүжилттэй холбоотой гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалсан байна.

Компанийн үйл ажиллагааны мөнгөн орлогын урсгалд олон улсын нүүрсний зах зээлийн үнийн бууралт шууд нөлөөлсөн. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч, гангийн хэрэглээ болон коксын үйлдвэрлэл буурсантай холбоотойгоор экспортын үнэ огцом буурч, Ганцмод боомт дээрх коксжих нүүрсний үнэ өмнөх оны мөн үеийн түвшинтэй харьцуулахад 53.0 хувиар буурсан байна. Үүний улмаас борлуулсан нүүрсний хэмжээ 9.0 хувиар өссөн хэдий ч борлуулалтын орлого 41.0 хувиар буурч, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд сөрөг нөлөө үзүүлсэн. Оны хоёрдугаар хагаст нүүрсний үнэ тодорхой хэмжээнд сэргэсэн боловч оны эхний хагаст үүссэн орлогын гүйцэтгэл төлөвлөсөн түвшнээс доогуур байсан нөлөөллийг бүрэн нөхөх боломж бүрдээгүй байна.

Компанийн хувьд зах зээлийн энэхүү хүндрэлтэй нөхцөлд Засгийн газрын шийдвэрээр хэрэгжиж буй улсын стратегийн ач холбогдол бүхий төслүүдийн санхүүжилтийг үргэлжлүүлэн хангаж ажилласан. Тухайлбал, Засгийн газрын 2022 оны 94 дүгээр тогтоолын дагуу хэрэгжиж буй газрын тос дамжуулах хоолойн төсөлд 266.5 сая ам.долларын буюу ойролцоогоор 919,405.9 сая төгрөгийн санхүүжилтийг нүүрсний нийлүүлэлтээр төвлөрүүлсэн байна.

Мөн компанийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор дэд бүтцийн томоохон төслүүдэд их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн. Үүнд: Гашуунсухайт–Ганцмод чиглэлийн хил дамнасан төмөр замын төсөлд 254,657.9 сая төгрөг, нүүрс тээврийн конвейрийн системийн төсөлд 244,014.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Эдгээр төслүүд нь богино хугацаанд мөнгөн хөрөнгийн нөөцөд тодорхой дарамт үзүүлсэн боловч урт хугацаанд тээврийн зардлыг бууруулах, экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх, компанийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх стратегийн ач холбогдолтой юм.

Авлагын данс

2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар компанийн нийт авлага 1,030,611.5 сая төгрөгт хүрч, өмнөх оны 978,149.7 сая төгрөгтэй харьцуулахад 52,461.8 сая төгрөгөөр буюу 5.4 хувиар өссөн байна. Авлагын үлдэгдэл нэмэгдсэн нь үндсэндээ төлбөр тооцооны хугацааны зөрүүтэй холбоотой бөгөөд 12 дугаар сард хийгдсэн нүүрсний борлуулалтын төлбөрүүд тайлант хугацааны эцэст Монголын хөрөнгийн биржийн шилжилтийн дансанд үлдсэнтэй холбоотой байна.

Нийт авлагын бүтцэд гадаад харилцагчаас авах авлага 723,224.9 сая төгрөг буюу 70.2 хувийг эзэлж, давамгайл байр суурьтай байна. Үүний 644,724.7 сая төгрөг буюу 89.1 хувь нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хийсэн нүүрсний цахим арилжаатай холбоотой төлбөр тооцооны үлдэгдэл юм. Тайлант онд тус биржээр нийт 12.6 сая тонн нүүрс борлуулж, 804.3 сая ам.долларын орлого олсон бөгөөд 12 дугаар сарын арилжааны төлбөрүүд тайлант хугацааны эцэст шилжилтийн дансанд үлдсэн байна. Мөн гадаад харилцагчдаас JASN International Pte. Ltd-ийн 52,811.4 сая төгрөг, Glory Town Holdings Limited-ийн 18,644.3 сая төгрөг, Xianghui Energy (Singapore)-ийн 6,540.1 сая төгрөгийн авлага тус тус бүртгэгдсэн байна.

Холбоотой талаас авах авлага 146,268.5 сая төгрөг байгаа нь нийт авлагын 14.2 хувийг эзэлж байна. Үүнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 15,350.0 сая төгрөг, Тавантолгой төмөр зам ХХК-ийн 130,918.5 сая төгрөгийн авлага багтсан бөгөөд эдгээр нь Засгийн газрын шийдвэрээр хэрэгжиж буй стратегийн төслүүдийн санхүүжилттэй холбоотой байна. Мөн Багануур ХК, Шивээ-Овоо ХК болон Эрдэнэс Монгол ХХК-д олгосон зээлийн санхүүжилттэй холбоотой 3,959.4 сая төгрөгийн хүүгийн авлага бүртгэгдсэн байна.

Авлагын насжилтын шинжилгээгээр нийт авлагын 35.2 хувь буюу 362,695.6 сая төгрөг нь тайлант жил үүссэн шинэ авлага байна. Харин 360 хоногоос дээш хугацаанд үүссэн авлага 667,915.9 сая төгрөг буюу нийт авлагын 64.8 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний дийлэнх нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хийсэн нүүрсний цахим арилжаатай холбоотой төлбөр тооцооны үлдэгдэл байна.

Богино хугацаат авлагын чанарын үнэлгээнд үндэслэн Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу эрсдэлийн алдагдлын нөөцийг 21,546.3 сая төгрөгөөр бүрдүүлсэн нь богино хугацаат дансны авлага болох 718,806.9 сая төгрөгийн 3.0 хувьтай тэнцэж байна. Нөөцийн хэмжээг авлагын насжилт, зээлдэгчийн санхүүгийн байдал, төлбөрийн түүх зэрэг хүчин зүйлсэд үндэслэн тооцсон байна. Тайлант хугацаанд найдваргүй авлагын зардал 4,866.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийн 3,188.4 сая төгрөгтэй харьцуулахад 52.6 хувиар өссөн нь авлагын чанарт тодорхой хэмжээний эрсдэл үүссэнийг харуулж байна.

Урьдчилж төлсөн төлбөр/зардал данс

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн урьдчилж төлсөн зардал/тооцооны дансны нийт үлдэгдэл 2,046,126.7 сая төгрөг байна. Энэ нь өмнөх оны 2,821,204.1 сая төгрөгтэй харьцуулахад 775,077.4 сая төгрөгөөр буюу 27.5 хувиар буурсан үзүүлэлт юм. Урьдчилж гарсан зардлын үлдэгдэл буурсан нь ногдол ашгийн урьдчилгаа төлбөр 560,916.2 сая төгрөгийг тооцоо хаасантай холбоотой.

Урьдчилгаа төлбөрийн бүтцэд Тавантолгой төмөр зам ХХК-д олгосон урьдчилгаа төлбөр 1,937,187.0 сая төгрөг байгаа нь нийт урьдчилгааны 94.7 хувийг эзэлж байна. Энэхүү урьдчилгаа нь Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд олгосон санхүүжилттэй холбоотой бөгөөд Засгийн газрын шийдвэрийн дагуу Тавантолгой төмөр зам ХХК-д төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх зорилгоор олгогдсон. Төслийн ажил үргэлжилж байгаа тул урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл өндөр хэвээр байна.

Тоног төхөөрөмж, хөрөнгийн урьдчилгаа 47,228.5 сая төгрөг байгаагийн дийлэнх буюу 40,549.9 сая төгрөг нь Хуа Еэ Интернэйшнл компанид тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний хүрээнд олгогдсон урьдчилгаа төлбөр юм. Мөн Майнс ап ХХК-д уул уурхайн тоног төхөөрөмжийн урьдчилгаа 5,731.0 сая төгрөг, Дижитал повер ХХК-д олгосон 947.5 сая төгрөгийн урьдчилгаа тус тус байна. Холбогдох тоног төхөөрөмжүүд 2026 онд нийлүүлэгдэхээр төлөвлөгдсөн байна.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Онцгой байдлын ерөнхий газарт олгосон санхүүжилтийн үлдэгдэл 27,500.0 сая төгрөг байна. Тус төслийн хүрээнд 2025 онд нийт 890 мянган ширхэг мод тарих ажлыг зохион байгуулсан байна. Мөн Тавантолгой дулааны цахилгаан станцын төсөлд олгосон санхүүжилт 12,726.9 сая төгрөг, судалгаа хөгжүүлэлтийн зардлын урьдчилгаа 1,227.9 сая төгрөг, даатгалын урьдчилгаа 938.5 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Урьдчилж төлсөн татварын үлдэгдэл 9,047.0 сая төгрөг байгаагийн 7,253.5 сая төгрөг нь Том Татвар Төлөгчийн Газарт төлсөн АНМАТ болон НӨАТ-ын урьдчилгаа төлбөрөөс үүссэн илүү төлөлт бөгөөд 2026 оны татварын тайланд нөхөн тооцогдох юм. Мөн нийгмийн даатгалын шимтгэлийн урьдчилгаа 1,735.8 сая төгрөг, бусад татварын урьдчилгаа 57.7 сая төгрөг тус тус

бүртгэлтэй байна. Урьдчилгаа төлбөрүүд нь холбогдох гэрээ, төслүүдийн хүрээнд 2026 онд зардалд шилжихээр төлөвлөгдсөн байна.

Бараа материал данс

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн бараа материалын нийт үлдэгдэл 675,165.5 сая төгрөг байна. Энэ нь өмнөх оны 506,601.1 сая төгрөгтэй харьцуулахад 168,564.4 сая төгрөгөөр буюу 33.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Бараа материалын өсөлт нь үндсэндээ нүүрсний олборлолтын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор бэлэн бүтээгдэхүүн буюу нүүрс, тос, тослох материал, сэлбэг хэрэгслийн нөөц нэмэгдсэнтэй холбоотой. Түүнчлэн компанийн өөрийн өмчлөлийн уулын ажлын техникүүд нэмэгдсэн нь сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлэлтэд нөлөөлсөн байна.

Бараа материалын бүтцэд бэлэн бүтээгдэхүүн /нүүрс/ 608,946.6 сая төгрөг (90.2 хувь), түлш, шатахуун, тос, тослох материал, сэлбэг хэрэгсэл 43,785.0 сая төгрөг (6.5 хувь), хангамжийн материал 22,433.9 сая төгрөг (3.3 хувь) эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бэлэн бүтээгдэхүүн /нүүрс/ 26.3 хувиар, тос, тослох материал, сэлбэг хэрэгсэл 420.4 хувиар, хангамжийн материал 39.1 хувиар тус тус өссөн байна. Сэлбэг хэрэгслийн нөөцийн өсөлт нь компани уулын ажлын 30.0 хувийг өөрсдийн техникээр хийж гүйцэтгэхээр төлөвлөн шинээр уулын ажлын техникүүд нэмэгдсэнтэй шууд холбоотой.

Тайлант хугацаанд бараа материалын үнийн бууралтын гарзаар нийт 9,102.1 сая төгрөг бүрдүүлсэн байна. Үүнд бэлэн бүтээгдэхүүний (нүүрс) үнийн бууралт 6,922.4 сая төгрөг, түлш, шатахуун, сэлбэгийн үнийн бууралт 2,179.7 сая төгрөг тус тус багтсан. Тайлант хугацаанд битумт үл барьцалдах нүүрсний өртөг цэвэр боломжит үнэ цэнээс давсантай холбоотойгоор 6,728.2 сая төгрөгийн бараа материалын үнийн бууралтыг "Бусад зардал"-д тусгасан байна. Энэхүү үнийн бууралт нь зах зээлийн үнийн хэлбэлзэлтэй холбоотойгоор үүссэн болно.

Үндсэн хөрөнгө данс

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн үндсэн хөрөнгийн дансны нийт үнэ 2,755,105.9 сая төгрөгт хүрч, өмнөх оны 2,126,210.6 сая төгрөгөөс 628,895.3 сая төгрөгөөр буюу 29.6 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь нүүрс баяжуулах үйлдвэр, конвейрийн систем, дуусаагүй барилга байгууламжийн хөрөнгө оруулалт, мөн уул уурхайн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэнтэй шууд холбоотой бөгөөд компанийн хэрэгжүүлж буй стратегийн төслүүдийн ахиц дэвшил үндсэн хөрөнгийн өсөлтийг голлон бүрдүүлжээ.

Тайлант үеийн үндсэн хөрөнгийн бүтцийг авч үзвэл барилга, байгууламж 212,427.3 сая төгрөг, машин, тоног төхөөрөмж 237,438.4 сая төгрөг, тээврийн хэрэгсэл 883,417.8 сая төгрөг, тавилга эд хогшил 3,856.8 сая төгрөг, компьютер, дагалдах хэрэгсэл 4,005.2 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 79,421.1 сая төгрөг, дуусаагүй барилга байгууламж 1,334,539.3 сая төгрөгийг эзэлж байна. Компанийн техник, тоног төхөөрөмжийн парк нийт 292 ширхэг бөгөөд тайлант онд нэмэгдсэн 12 экскаватор, 77 автосамосвал, 26 туслах техник нь уулын ажлын 26.3 хувийг өөрийн техникээр гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн байна.

Тайлант хугацаанд нийт 733,653.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр бүртгэгдсэн бөгөөд үүнд барилга байгууламжийн 73,229.6 сая төгрөг, машин тоног төхөөрөмжийн 218,814.9 сая төгрөг, тээврийн хэрэгслийн 388,127.9 сая төгрөг, бусад хөрөнгийн 53,481.3 сая төгрөгийн нэмэгдэл тус тус багтаж байна. Нэмэгдлийн дийлэнх нь нүүрс баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, конвейрийн системийн барилга угсралт болон уул уурхайн хүнд даацын техникийн шинэчлэлтэй холбоотой байна.

Дуусаагүй барилга байгууламжийн үлдэгдэл 1,334,539.3 сая төгрөгт хүрч, өмнөх оны 1,293,607.4 сая төгрөгөөс 40,931.9 сая төгрөгөөр өссөн бөгөөд Зүүн цанхи уурхайн барилга байгууламж, Нүүрс баяжуулах үйлдвэр, Конвейрийн систем зэрэг 97–99 хувийн гүйцэтгэлтэй төслүүдийн санхүүжилт голлон бүрдүүлж байна. Эдгээр төсөл 2026 оны 2–5 дугаар саруудад ашиглалтад орох төлөвтэй байна. Тайлант онд дуусаагүй барилгын дансанд нийт 372,051.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, 331,115.5 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгө ашиглалтад орсноор үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн бөгөөд Нүүрс тээврийн ачих логистикийн төвийн барилга, Гаалийн хяналтын нүүрс ачиж буулгах талбай, Дотоодын цэргийн барилга, авто зам, агуулах зэрэг хөрөнгүүд багтжээ.

Компанийн хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл 158,076.4 сая төгрөг бөгөөд тайлант онд нийт 101,106.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна. Данснаас хасагдсан хөрөнгийн элэгдлийн бууралтаас шалтгаалан элэгдлийн нийт дүн 27,108.3 сая төгрөгөөр хорогджээ. Тайлант хугацаанд ашиглалтын хугацаа дууссан болон ашиглах боломжгүй болсон 71,692.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан бөгөөд эдгээр хөрөнгийн үлдэгдэл үнэ болон хуримтлагдсан элэгдлийг тооцсоны үндсэн дээр 145.6 сая төгрөгийн гарз орлогын дэлгэрэнгүй тайланд тусгагдсан байна.

Биет бус хөрөнгө

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн биет бус хөрөнгийн дансны үнэ 11,041,481.7 сая төгрөг байна. Энэ нь өмнөх оны 11,087,027.4 сая төгрөгтэй харьцуулахад 45,545.7 сая төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан үзүүлэлт юм. Биет бус хөрөнгийн бууралт нь үндсэндээ ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хорогдолтой холбоотой бөгөөд энэ нь тухайн жилийн олборлолтын хэмжээнд үндэслэн тооцогддог. Тайлант хугацаанд нийт 30.2 сая тонн нүүрс олборлосонтой уялдан 52,270.9 сая төгрөгийн хорогдлын зардал тооцсон байна.

Компанийн биет бус хөрөнгийн бараг 99.99 хувийг Тавантолгой ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэлж байна. Компани нь нийт 8 ашиглалтын тусгай зөвшөөрөл (MV-011943, MV-011953, MV-011954, MV-011955, MV-011956, MV-016881, MV-016882, MV-016883) эзэмшдэг бөгөөд эдгээр зөвшөөрлүүд нь 2013-2038 оны хугацаанд хүчинтэй. Тавантолгой ордын нийт нөөц 8.1 тэрбум тонн бөгөөд энэ нь компанийн урт хугацааны тогтвортой үйл ажиллагааны үндэс суурь болж байна. Тусгай зөвшөөрлийн үнэ цэнийг НББОУС 38-ын дагуу жил бүр үнэ цэнийн бууралтад хамруулан үнэлдэг.

Компани биет бус хөрөнгийн бүртгэлийг НББОУС 38 "Биет бус хөрөнгө"-ний дагуу хөтөлдөг. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хорогдлыг үйлдвэрлэлийн хэмжээнд пропорциональ аргаар тухайн жилийн олборлолтын хэмжээнд үндэслэн нийт нөөцөд харьцуулан тооцдог бол компьютерийн программ хангамжийн хорогдлыг шулуун шугамын аргаар 3-5 жилийн хугацаанд тооцдог. Мөн НББОУС 36 "Хөрөнгийн үнэ цэнийн бууралт"-ын дагуу биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг жил бүр үнэлж, шаардлагатай тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарз тооцдог.

Тайлант хугацаанд геологи хайгуулын ажлын хүрээнд нийт 152 цооног, 49,129.16 тууш метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэсэн байна. Эдгээр хайгуулын ажлын үр дүнд Цанхийн баруун уурхайн хойд хэсгээс сайн чанарын 1/3 коксжих нүүрс илрүүлж, ордын нөөцийн мэдээллийг шинэчилсэн, уурхайн байнгын хананы тогтворжилтын тооцоолол хийсэн байна. Шинээр илрүүлсэн нүүрсний бүтээгдэхүүн нь үнслэг 10.0 хувиас бага, дэгдэмхий бодис 37.0 хувиас бага, барьцалдах шинж чанар 80.0 хувиас дээш, хүхэр 0.6 хувиас бага чанартай бөгөөд зах зээлд өндөр үнэ цэнэтэй бүтээгдэхүүн болох боломжтой байна.

Мөн эрчим хүчний нүүрснээс устөрөгч гарган авах суурь судалгаа, гөлтгөнийн баяжицын судалгаа зэрэг судалгаа, шинжилгээний ажлууд хийгдсэн нь ирээдүйд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нээж байна. Тодруулбал, гөлтгөнийн баяжицын судалгаагаар MNS 0962:1986 стандартын дагуу III зэрэглэлийн >65% цэвэршилттэй гөлтгөнийн чулуу гарган авах боломжтойг тогтоосон нь уурхайн дагалдах бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлж байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалт

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн урт хугацаат хөрөнгө оруулалтын нийт дүн 2,040,526.9 сая төгрөг байна. Энэ нь өмнөх оны 1,346,763.7 сая төгрөгтэй харьцуулахад 693,763.2 сая төгрөгөөр буюу 51.5 хувиар өссөн. Хөрөнгө оруулалтын өсөлт нь "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн эзэмшлийн хувь 66 хувиас 100 хувь болж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тавантолгой төмөр зам ХХК-д эзэмшиж байсан хувь өмнөх онд 66 хувь байсан бөгөөд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоол, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 04 дүгээр тогтоол, мөн "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 01 дүгээр тогтоолын дагуу

Монголын төмөр зам ТӨХК-ийн эзэмшилд байсан 34 хувийн хувьцааг шилжүүлэн авснаар эзэмшлийн хувь 100 хувь болж, уг хөрөнгө оруулалтын дансны үнэ 2,040,479.7 сая төгрөг болсон байна.

Тавантолгой төмөр зам ХХК-ийн хэрэгжүүлж буй Гашуунсухайт–Ганцмод чиглэлийн хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын төсөл бүрэн хэрэгжиж, ашиглалтад орсноор Монгол Улсын боомтын нэвтрүүлэх хүчин чадал хоёр дахин нэмэгдэж, нүүрсний экспортын хэмжээ жилд дунджаар 165 сая тоннд хүрэх боломж бүрдэх төлөвтэй байна.

Бусад хөрөнгө оруулалтад Тавантолгой түлш ХХК (51.0 хувь), Гашуунсухайт авто зам ХХК (40.0 хувь), Зүүнбаян төмөр зам ХХК (66.0 хувь), Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХК (30.0 хувь) багтах бөгөөд эдгээр нь нийт хөрөнгө оруулалтын 0.1 хувиас бага хувийг эзэлж байна. Эдгээр хөрөнгө оруулалт нь Засгийн газрын холбогдох тогтоолуудын дагуу (2021 оны 316 дугаар тогтоол, 2020 оны 117 дугаар тогтоол, 2020 оны 175 дугаар тогтоол) компанийн эзэмшилд шилжсэн бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн байна.

Эдгээр хөрөнгө оруулалт нь компанийн "Уул уурхай, Дэд бүтэц, Аж үйлдвэрлэл" хөгжлийн жишгийн хүрээнд стратегийн ач холбогдолтой бөгөөд нүүрс тээврийн логистикийн үр ашгийг дээшлүүлэх, тээврийн зардлыг бууруулах, экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, уурхайн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг найдвартай хангахад чиглэгдсэн байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгө

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн бусад эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн 3,554,366.6 сая төгрөг байна. Энэ нь өмнөх оны 3,752,946.8 сая төгрөгтэй харьцуулахад 198,580.2 сая төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан үзүүлэлт юм. Бууралт нь үндсэндээ хөрс хуулалтын хөрөнгийн элэгдэл, урт хугацаат авлагын богино хугацаат хэсэг рүү шилжүүлсэн, мөн урт хугацаат нөхөн сэргээлтийн хөрөнгийн үнэлгээний өөрчлөлттэй холбоотой.

Урт хугацаат авлагын нийт дүн 3,673,616.2 сая төгрөг байгаа нь өмнөх оны 3,418,946.1 сая төгрөгтэй харьцуулахад 254,670.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ хэсэгт "Монголын төмөр зам" ТӨХК, "Тавантолгой түлш" ХХК, "МГТБҮ" ТӨХК, "Чингис хаан банк" ХХК, "Шивээ Овоо" ХХК, "Багануур" ХК зэрэг холбоотой болон гуравдагч этгээдэд олгосон урт хугацаат зээл, санхүүжилт багтаж байна. Урт хугацаат авлагыг СТОУС 9-ийн дагуу хорогдуулсан өртгийн аргаар хэмждэг бөгөөд тайлант хугацаанд 101,777.9 сая төгрөгийн богино хугацаат хэсгийг "Бусад авлага" руу шилжүүлсэн байна.

Урт хугацаат авлагын хасагдуулга 976,369.4 сая төгрөг байгаа нь өмнөх оны 923,456.2 сая төгрөгтэй харьцуулахад 52,913.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Хасагдуулгын хэмжээг зээлдэгч тус бүрийн зээлийн чадвар, төлбөрийн түүх, санхүүгийн байдал, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн тооцдог бөгөөд энэ нь урт хугацаат авлагын чанарын бодит үнэлгээг илэрхийлж байна.

Хөрс хуулалтын хөрөнгийн үлдэгдэл 746,221.7 сая төгрөг байгаа нь өмнөх оны 1,092,655.3 сая төгрөгтэй харьцуулахад 346,433.6 сая төгрөгөөр буюу 31.7 хувиар буурсан байна. Хөрс хуулалтын хөрөнгийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хорооны "Тайлбар 20", НББОУС 2 болон холбогдох бусад стандартуудыг баримтлан боловсруулсан "Хөрс хуулалтын хөрөнгө, түүний элэгдлийг бүртгэх аргачлал"-ын дагуу тооцдог бөгөөд тайлант хугацаанд бүтээгдэхүүний нэгжид ногдох аргаар элэгдэл тооцсон байна.

Урт хугацаат нөхөн сэргээлтийн хөрөнгийн үлдэгдэл 35,166.5 сая төгрөг байгаа нь өмнөх оны 117,985.8 сая төгрөгтэй харьцуулахад 82,819.3 сая төгрөгөөр буюу 70.2 хувиар буурсан байна. НББОУС 37-ийн дагуу уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн сангийн тооцооллыг хийж, уурхайн хаалт нөхөн сэргээлтийн хөрөнгийг бүртгэсэн. 2025 онд дискаунтын түвшин өссөнтэй холбоотойгоор үнэлгээ өөрчлөгдсөн байна. Мөн энэ хөрөнгийг бүтээгдэхүүний нэгжид ногдох аргын дагуу хорогдуулан бүртгэдэг.

Бүтээн байгуулалтын зардал 76,423.5 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийн 52,914.4 сая төгрөгтэй харьцуулахад 23,509.1 сая төгрөгөөр буюу 44.4 хувиар өссөн байна. Энэ хэсэгт нүүрс баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, конвейрийн системийн нэмэлт байгууламж, уурхайн

дэд бүтцийн шинэчлэл зэрэг хөрөнгө оруулалтын төслүүдийн бүтээн байгуулалтын зардал багтсан байна. СТОУС 6 болон Монгол улсын сангийн сайдын 409 дүгээр тушаалын дагуу эдгээр зардлыг бүртгэж, үнэ цэнийн бууралтад хамруулан үнэлдэг.

Өр төлбөр данс

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн нийт өр төлбөр 9,019,871.4 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийн 6,635,619.0 сая төгрөгтэй харьцуулахад 2,384,252.4 сая төгрөгөөр буюу 35.9 хувиар өссөн байна. Өр төлбөрийн өсөлт нь 2024 оны ашгаас тооцсон 2,879,862.7 сая төгрөгийн төрд ногдох ногдол ашгийн өглөгийг бүртгэсэнтэй холбоотой. Нийт өр төлбөрийн бүтцэд урт хугацаат өр төлбөр 6,540,992.2 сая төгрөг буюу 72.5 хувь, богино хугацаат өр төлбөр 2,478,879.3 сая төгрөг буюу 27.5 хувийг тус тус эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөр 6,540,992.2 сая төгрөг байгаагаас 6,448,048.2 сая төгрөг буюу 98.6 хувь нь бусад урт хугацаат өр төлбөрт бүртгэгдсэн төрд ногдох ногдол ашгийн өглөг байна. Үүнд өмнөх онд богино хугацаат өр төлбөрт бүртгэлтэй байсан 2022–2023 оны ногдол ашгийн өглөг 3,305,196.7 сая төгрөгийг тайлант хугацаанд урт хугацаат өр төлбөрт шилжүүлэн ангилсан дүн, мөн 2024 онд үүссэн 2,879,862.7 сая төгрөгийн ногдол ашгийн өглөгийг урт хугацаат өглөгт тусгасан дүн багтаж байна.

Түүнчлэн өмнөх оны урт хугацаат ногдол ашгийн үлдэгдэл 762,988.7 сая төгрөгөөс 500,000.0 сая төгрөгийг тайлант хугацаанд барагдуулж, үлдэгдэл 262,988.7 сая төгрөг бүртгэлтэй байна. Урт хугацаат өр төлбөрийн бүрэлдэхүүнд мөн уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн сангийн нөөц 50,391.4 сая төгрөг, хойшлогдсон татварын өр 42,552.5 сая төгрөг тус тус багтаж байна.

Богино хугацаат өр төлбөрийн дийлэнхийг ирээдүйд нийлүүлэх нүүрсний төлбөрт худалдан авагчдаас урьдчилан авсан орлого 1,689,357.9 сая төгрөг эзэлж байна. Мөн дансны өглөг 282,313.3 сая төгрөг, татварын өр 79,162.8 сая төгрөг, цалингийн өглөг 19,433.7 сая төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 408,611.6 сая төгрөг тус тус бүртгэгдсэн байна.

Дансны өглөгийн бүтцэд уурхайн үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээт гүйцэтгэгчдэд төлөх өглөг 149,049.0 сая төгрөг, нүүрс тээврийн үйлчилгээний өглөг 46,549.1 сая төгрөг, шатахууны нийлүүлэлтийн өглөг 13,973.9 сая төгрөг, сэлбэг материалын нийлүүлэлтийн өглөг 23,075.1 сая төгрөг, Эрдэнэс Монгол ХХК-д төлөх менежментийн өглөг 20,953.6 сая төгрөг, бусад гэрээт ажлын 28,712.6 сая төгрөгийн өглөг тус тус багтаж байна. Уурхайн үндсэн гэрээт гүйцэтгэгчдэд төлөх өглөгт ТиТиЖиВиСиӨү ХХК-ийн 78,126.8 сая төгрөг, Эрдэсмайнинг оператор ХХК-ийн 15,786.4 сая төгрөг, Овоот толгой ресурсес ХХК-ийн 16,626.4 сая төгрөг, Үндэсний манлайлал түншлэлийн 15,609.9 сая төгрөг, Үндэсний уурхайчид түншлэлийн 10,067.1 сая төгрөг, Кэй Эй Майнинг ХХК-ийн 6,696.9 сая төгрөг, Спейшл Майнинг ХХК-ийн 6,135.5 сая төгрөгийн өглөг тус тус бүртгэгдсэн байна.

Бусад богино хугацаат өр төлбөрт гадаад харилцагчдад буцаан олгох барьцаа төлбөр 356,333.6 сая төгрөг, дотоод нийлүүлэгчдээс авсан барьцаа төлбөр 41,239.5 сая төгрөг, үндсэн хөрөнгийн худалдан авалттай холбоотой 10,656.5 сая төгрөг, бусад харилцагчидтай холбоотой 382.0 сая төгрөгийн өглөг багтсан байна. Гадаад харилцагчдын барьцаа төлбөрт Xianghui Energy, Sinomach Hainan Development, Yueyang Sinoma, Xinxing Pipes зэрэг нүүрс худалдан авагч компаниудын төлбөрүүд багтаж байна. Тайлант хугацаанд бусад богино хугацаат өр төлбөр 408,611.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийн 362,330.6 сая төгрөгтэй харьцуулахад 12.8 хувиар өссөн нь гадаад харилцагчдын барьцаа төлбөрийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Татварын өр төлбөрийн нийт үлдэгдэл 79,162.8 сая төгрөг байна. Үүнээс 76,822.8 сая төгрөг нь тайлант жилийн үйл ажиллагааны үр дүнгээр тооцсон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, 1,948.1 сая төгрөг нь үл хөдлөх хөрөнгийн албан татвар, 230.0 сая төгрөг нь агаарын бохирдлын төлбөр, 142.6 сая төгрөг нь хувь хүний орлогын албан татвар, 19.3 сая төгрөг нь газрын болон усны төлбөрийн өр төлбөр байна.

Эздийн өмч данс

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн эздийн өмчийн нийт дүн 14,665,239.8 сая төгрөг байна. Энэ нь өмнөх оны 17,414,361.5 сая төгрөгтэй харьцуулахад

2,749,121.7 сая төгрөгөөр буюу 15.8 хувиар буурсан үзүүлэлт юм. Уг өөрчлөлтөд хуримтлагдсан ашгийн бууралт голлон нөлөөлсөн байна.

Компанийн хувьцаат капитал 11,196,000.0 сая төгрөг байх бөгөөд нийт хувьцааны тоо 12,000,000,000 ширхэг, нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 933 төгрөг байна. Хувьцаа эзэмшлийн бүтцэд Төрийн эзэмшил 73.5 хувь, Монгол Улсын иргэд 26.4 хувь, аж ахуйн нэгжүүд 0.1 хувь тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд хувьцаат капиталд өөрчлөлт ороогүй байна.

Хуримтлагдсан ашгийн үлдэгдэл 3,395,946.9 сая төгрөг болж, өмнөх оны 6,143,325.3 сая төгрөгтэй харьцуулахад 2,747,378.4 сая төгрөгөөр буюу 44.7 хувиар буурсан байна. Энэхүү өөрчлөлт нь тайлант хугацаанд 2024 оны цэвэр ашгаас 3,918,000.0 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилсантай холбоотой. Тайлант хугацааны цэвэр ашиг 1,123,809.4 сая төгрөг байсан нь эздийн өмчийн бууралтыг хэсэгчлэн нөхсөн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн үлдэгдэл 75,036.2 сая төгрөг байгаа нь өмнөх оны түвшинд хэвээр байна. Энэ нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнээс үүссэн бөгөөд НББОУС 16 "Үндсэн хөрөнгө"-ний дагуу бүртгэгдсэн байна. Мөн эздийн өмчийн бусад хэсэгт 1,743.3 сая төгрөг байх бөгөөд энэ нь ажилчдын тэтгэврийн сангийн дахин хэмжилтийн гарз бүртгэгдсэн байна.

Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг 93.65 төгрөг байгаа нь өмнөх оны 377.37 төгрөгтэй харьцуулахад эрс буурсан үзүүлэлт юм. Энэ нь тайлант хугацааны цэвэр ашиг 4,528,406.8 сая төгрөгөөс 1,123,809.4 сая төгрөг болж 75.2 хувиар буурсантай холбоотой. Цэвэр ашгийн бууралт нь үндсэндээ нүүрсний үнийн уналт, борлуулалтын орлого буурсантай холбоотой.

Тайлант хугацаанд "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 34 хувийн хувьцааг "Монголын төмөр зам" ТӨХК-аас шилжүүлэн авсан нь өмчийн бүтцэд шууд нөлөөлөөгүй боловч охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийг нэмэгдүүлсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3 -т заасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталжээ. Тус төлөвлөгөөгөөр батлагдсан компанийн 2025 оны төсвийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоол, 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 25 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 7,043,554.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,903,160.1 сая төгрөгөөр, татварын өмнөх ашигийг 2,140,394.5 сая төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,618,162.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 6,046,288.5 сая төгрөгийн борлуулалтын орлого, 703,630.3 сая төгрөгийн бусад орлого, нийт 6,749,918.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,261,580.4 сая төгрөгийн зардал гарган, 1,488,338.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Уулын ажил

Эрдэнэс тавантолгой ХК-нь 2025 онд Цанхийн зүүн болон баруун уурхайгаас нийт 30.0 сая тонн нүүрс олборлож, 180.5 сая м³ хөрс хуулах, 201.9 сая м³ уулын цул шилжүүлэхээр төлөвлөснөөс тайлант хугацаанд 30.2 сая тонн нүүрс олборлож, 181.5 сая м³ хөрс хуулж, 203.1 сая м³ уулын цул шилжүүлсэн нь төлөвлөгөөний биелэлт нүүрс олборлолт 100.7 хувь, хөрс хуулалт 100.6 хувь, уулын цул шилжүүлэлт 100.6 хувь байна.

Нүүрс баяжуулах үйлдвэрлэл

Нүүрс баяжуулах үйлдвэрт 1,839.0 мянган тонн тэжээл боловсруулж, 76.6 хувийн гарцтай, 1,408.0 мянган тонн бүтээгдэхүүн гаргах төлөвлөгөө баталсан.

Тайлант онд 1,593.9 мянган тонн тэжээл хүлээн авч, 55.1 хувийн гарцтай 355.1 мянган тонн баяжуулсан коксжих бүтээгдэхүүн, 53.2 хувийн гарцтай 501.6 мянган тонн баяжуулсан сул коксжих бүтээгдэхүүн, 19.5 хувийн гарцтай 310.1 мянган тонн баяжуулсан коксжих чанаргүй нүүрс тус тус үйлдвэрлэсэн ба нийт 73.4 хувийн гарцтай 1,166.8 мянган тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Мөн “Тавантолгой түлш” ХХК-ийн захиалгаар утаагүй түлшний туршилтын түүхий эд нийлүүлэх зорилгоор 6 мянган тонн эрчим хүчний нүүрс туршилтаар баяжуулж 55 хувийн гарцтай 3.3 мянган тонн баяжуулсан эрчим хүчний нүүрс үйлдвэрлэсэн байна.

Борлуулалтын орлогын гүйцэтгэл

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2025 оны борлуулалтын орлого 6,046,288.5 сая төгрөгөөр бүртгэгдэж, батлагдсан төсвийн 6,693,610.0 сая төгрөгтэй харьцуулахад 647,321.5 сая төгрөгөөр дутуу буюу 90.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Нүүрсний борлуулалтын биет хэмжээгээр авч үзвэл тайлант хугацаанд 30.0 сая тонн нүүрс борлуулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 27.6 сая тонн нүүрс борлуулж, төлөвлөгөөний хэрэгжилт 92.1 хувьтай байна. Энэ нь төлөвлөсөн хэмжээнээс 2.4 сая тонноор бага гүйцэтгэлтэй байгааг харуулж байна.

Нэг тонн нүүрсний дундаж борлуулалтын үнийг 62.0 ам.доллар байхаар төсөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд гүйцэтгэлээр 61.9 ам.долларт хүрч, төлөвлөсөн түвшинтэй дүйцэх хэмжээнд байна. Иймд борлуулалтын орлогын хэлбэлзэлд үнийн өөрчлөлтөөс илүүтэйгээр борлуулсан нүүрсний биет хэмжээний гүйцэтгэл голлон нөлөөлсөн байна. Энэ нь гадаад зах зээл дэх нүүрсний эрэлт, нийлүүлэлтийн нөхцөл болон экспортын хэмжээний өөрчлөлттэй холбоотой байна.

Өмнөх онтой харьцуулахад борлуулалтын орлого 10,250,718.8 сая төгрөгөөс 6,046,288.5 сая төгрөг болж 4,204,430.3 сая төгрөгөөр буюу 41.0 хувиар буурсан.

Энэхүү бууралт нь 2025 онд нүүрсний зах зээлийн үнэ мэдэгдэхүйц буурсантай шууд холбоотой. Мөн эрчим хүчний, сул коксжих болон баяжуулсан нүүрсний экспортын хэмжээ нэмэгдсэнээр борлуулалтын бүтцэд хатуу коксжих нүүрсний эзлэх хувь өмнөх онтой харьцуулахад 21.1 хувиар буурсан байна. Энэ нь компанийн нүүрсний олборлолт, борлуулалтыг зөвхөн өндөр чанарын нэг төрлийн нүүрсэнд төвлөрүүлэхгүй, бүтээгдэхүүний бүтцийг төрөлжүүлэх бодлоготой нийцэж байна.

Нийт зардлын гүйцэтгэл 5,261,580.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 720,165.3 сая төгрөг буюу 14.7 хувиар хэтэрсэн байна. Үүнд борлуулсан бүтээгдэхүүний өртгийн өсөлт гол нөлөө үзүүлсэн байна.

Борлуулалтын өртөг 2025 онд 3,256,151.3 сая төгрөгөөр бүртгэгдэж, батлагдсан төсвийн 2,528,788.0 сая төгрөгтэй харьцуулахад 727,363.3 сая төгрөгөөр давж, 128.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн өмнөх онтой харьцуулахад 1,338,693.2 сая төгрөгөөр буюу 1.7 дахин өссөн байна. Энэ нь бүтээгдэхүүний өртөг тооцох, хуваарилах аргачлалд хийсэн өөрчлөлттэй холбоотой.

Тухайлбал, НББОУС 2 “Бараа материал”-ын хамсарсан бүтээгдэхүүний зардлыг оновчтой суурьт үндэслэн хуваарилах зарчимд нийцүүлэн хамсарсан бүтээгдэхүүний өртгийг өмнө нь тоо хэмжээний аргаар хуваарилж байсныг 2025 оноос борлуулалтын үнийн аргаар хуваарилах болсон, мөн СТОУТХ 20 “Ил уурхайн үйлдвэрлэлийн үе шат дахь хөрс хуулалтын зардал”-д заасан зарчимтай нийцүүлэн хөрс хуулалтын зардлыг бүртгэх аргачлалд өөрчлөлт орж, ордын бүрэлдэхүүн хэсэгт суурилан тооцох болсон нь тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний өртөг өсөхөд голлон нөлөөлсөн байна.

Ашигт ажиллагааны гүйцэтгэлийн нэгдсэн үнэлгээ

Тайлант онд компанийн цэвэр ашиг 1,123,809.4 сая төгрөг болж, төлөвлөсөн түвшнээс 482,386.5 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад борлуулалтын орлого 41.0 хувиар буурч, борлуулалтын өртөг 69.8 хувиар өссөн нөлөөгөөр цэвэр ашиг 4,528,406.8 сая төгрөгөөс 1,123,809.4 сая төгрөг болж 75.2 хувиар буурсан байна.

Энэхүү өөрчлөлт нь нүүрсний олон улсын зах зээл дэх үнийн огцом бууралт болон бүтээгдэхүүний өртөг тооцох, хуваарилах аргачлалд хийсэн өөрчлөлтөөс шалтгаалан борлуулалтын өртөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Мөн компанийн ашигт ажиллагааны гол үзүүлэлтүүд болох нийт хөрөнгийн өгөөж (ROA) болон эздийн өмчийн өгөөж (ROE) 2022–2024 онуудад тогтвортой өсөлттэй байсан бөгөөд тухайн хугацаанд 12.2–16.2 хувийн түвшинд хүрч өссөн бол 2025 онд ROA 4.7 хувь, ROE 7.0 хувь болж буурсан байна.

Эздийн өмчийн өгөөжийн бууралтад цэвэр ашгийн түвшин болон хөрөнгийн эргэц буурсан нь голлон нөлөөлсөн бол санхүүгийн хөшүүргийн түвшин энэ хугацаанд тодорхой хэмжээгээр сайжирсан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 524 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 1,126,972.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2025 оны нийт хөрөнгө оруулалтын төсөв 9,152,515.3 сая төгрөг, үүнээс тухайн жилд санхүүжих хэмжээ 1,618,162.8 сая төгрөг байна. Хөрөнгө оруулалтын бүтцэд: томоохон төслүүд 8,118,006.8 сая төгрөг (санхүүжих: 1,165,770.3 сая төгрөг), компанид хийгдэх хөрөнгө оруулалт 307,474.2 сая төгрөг (санхүүжих: 91,462.0 сая төгрөг), он дамжих хөрөнгө оруулалт 727,034.3 сая төгрөг (санхүүжих: 360,930.5 сая төгрөг) тус тус эзэлж байна. Томоохон төслүүд нь стратегийн дэд бүтцийн багцуудыг багтаасан бөгөөд Гашуунсухайт–Ганцмодын хил дамнасан төмөр зам, Тавантолгой–Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, нүүрс ачих логистикийн төв, холболтын шугам, нүүрс баяжуулах үйлдвэр, конвейрийн систем, ус хангамжийн төсөл болон Тавантолгой дулааны цахилгаан станц зэрэг үндсэн төслүүдийг санхүүжүүлэхээр тусгагдсан.

Компанийн дотоод хөрөнгө оруулалт нь уурхайн барилга байгууламж, техник тоног төхөөрөмж, машин механизм, мэдээллийн технологийн хүчин чадал, камер-аюулгүй байдлын систем, биет бус хөрөнгө болох геологийн сорьц-шинжилгээ, зөвлөх үйлчилгээ, программ хангамж зэрэг үйл ажиллагааны үр ашиг, найдвартай байдлыг сайжруулах чиглэлтэй байна. Он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтад засвар механикийн төв, гаалийн хяналтын бүс, ажилчдын хотхон, цахилгаан, дулаан, усны шугам сүлжээ, авто замын байгууламж, уурхайн техник, удирдлагын систем болон хамгаалалтын дэд бүтэц зэрэг өмнөх онуудын үргэлжилж буй төслүүд хамрагдсан. Эдгээр хөрөнгө оруулалт нь компанийн тээвэр логистикийн хүчин чадал, үйлдвэрлэлийн үнэ цэнэ, эрчим хүчний найдвартай ажиллагаа, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, дотоод хяналт удирдлагын дижитал орчныг зэрэгцээ ахиулах зорилготой.

Бодит гүйцэтгэлээр компани 1,126,973.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь санхүүжилтийн 69.6 хувийн биелэлттэй байна. Гүйцэтгэлийн ихэнх хэсэг нь дуусаагүй барилга, урт хугацаат авлага, урьдчилгаа зардлууд зэрэг үргэлжилж буй төслүүдэд ноогдсон байна.

Томоохон төслүүдийн хүрээнд батлагдсан 8,118,006.8 сая төгрөгийн төсвөөс 1,165,770.3 сая төгрөг санхүүжиж, үүнээс 897,949.7 сая төгрөгийн бодит гүйцэтгэл хийгдсэн нь 77.0 хувийн биелэлттэй байна. Төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, ус хангамж, конвейрийн систем зэрэг үйлдвэрлэл, дэд бүтцийн үндсэн төслүүд тогтвортой хэрэгжиж байгаа нь уурхайн үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлэх стратегийн зорилттой уялдаж байна. Ийнхүү хөрөнгө оруулалтын гүйцэтгэл нь дундаас дээш түвшинд биелж, хэрэгжиж буй олон төсөл 2026 онд үргэлжлэн санхүүжих бүтэцтэй байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тайлант онд түрээсийн орлогын 40 хувь буюу 72.0 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

Байгууллагын орон тооны цомхотголын талаар

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2025 оны анхны батлагдсан төсөвт нийт орон тоог 2,244 нэгж, цалингийн зардлын санг 433,658.5 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна. Тайлант хугацаанд ажиллагчдын дундаж тоо 1,997 нэгж байсан нь батлагдсан орон тооноос 247 нэгжээр буюу 11.0 хувиар бага байна. Үүнтэй уялдан цалингийн зардал 374,171.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу батлагдсан төсвөөс 59,486.7 сая төгрөгөөр буюу 13.7 хувиар бага байна.

Батлагдсан орон тоотой харьцуулахад ажиллагчдын бүрдэлт 89.0 хувьтай биелсэн нь цалингийн зардлын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнээс хэмнэлттэй гарахад голлон нөлөөлсөн бөгөөд энэ нь хүний нөөцийн бүрдүүлэлт хангалтгүй байх, ажлын байрны нөхөн хангалт удаашрах, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтүүд бүрэн хэрэгжээгүй зэрэг хүчин зүйлүүдтэй шууд холбоотой байна.

Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар

Эрдэнэс Тавантолгой ХК нь 2024 онд баталсан ЭТТ-2024/1631 дугаар Хамтын гэрээний дагуу ажилтнуудад олгох хоол, унааны хөнгөлөлтийн хэмжээг нэг ажилтанд 40,000 төгрөгөөр тогтоосон байна. Тайлант хугацаанд тус хөнгөлөлтийн зардалд нийт 1,698.4 сая төгрөг зарцуулсан нь хамтын гэрээгээр тогтоосон нөхцөлийн дагуу ажилтнуудад олгосон нийгмийн хангамжийн зардлын нэг хэсгийг бүрдүүлж байна.

Зах зээлийн жишиг үзүүлэлттэй харьцуулан үзэхэд уул уурхайн болон томоохон аж ахуйн нэгжүүдэд ажилтнуудад олгож буй хоол, унааны дэмжлэгийн хэмжээ дунджаар 30,000–50,000 төгрөгийн хооронд хэлбэлздэг байна.

Гадаад томилолт, арга хэмжээний талаар

Тайлант хугацаанд компанийн гадаад томилолт БНХАУ, Канад, ХБНГУ, Япон, Испани, БНСУ, Тайланд, АНУ зэрэг нийт 8 улсад хэрэгжсэн байна. Эдгээр томилолтод нийт 853.2 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд томилолтын нислэгийн тийз болон холбогдох үйлчилгээний төлбөрийг ЭЙРТРАНС ХХК, Монстер Трэйвэл ХХК, Тахилт хайрхан транс ХХК зэрэг аялал жуулчлал, тээврийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаар дамжуулан гүйцэтгэсэн байна.

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний талаар

Тайлант онд харьцуулалтын аргаар тендер зохион байгуулж шалгарсан 4 байгууллагатай нийт 205.4 сая төгрөгийн гэрээ байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагаа, даралтат сав, шугам хоолойтой ажиллах, оосорлогч дохиочны эрх олгох болон сунгах зэрэг үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбоотой сургалтуудыг зохион байгуулсан байна.

Мөн 12 байгууллагатай нийт 134.7 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж, стратеги төлөвлөлт, цахилгаан болон механикийн ашиглалт, засвар, химийн болон цацрагийн аюулгүй ажиллагаа, баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагаа, хүний нөөцийн менежмент зэрэг мэргэжлийн чиглэлийн сургалтуудыг хэрэгжүүлжээ. Түүнчлэн эрсдэлийн менежмент, 5S хөдөлгөөн, хууль эрх зүй, дата анализ, мэргэшсэн нягтлан бодох бүртгэл, татвар, хүний нөөц, хувь хүний хөгжил зэрэг цаг үеийн шинжтэй 13 төрлийн сургалтыг зохион байгуулж, нийт 123.9 сая төгрөг зарцуулсан байна.

Программ хангамжийн бүртгэл, тайлагналын талаар

Байгууллагын үйл ажиллагаанд 24 төрлийн программ хангамж ашиглагдаж байна. Үүнээс 16 программ хангамжийг байгууллагын үндсэн үйл ажиллагаанд, 5 программ хангамжийг дотоод удирдлага, тайлагнал, мэдээлэл боловсруулах чиглэлээр ашиглаж байгаа бол 3 программ хангамж ашиглалтгүй байна. Мөн судалгаанд хамрагдсан программ хангамжаас 18 нь лицензтэй, 4 нь нээлттэй эхийн программ, 2 программ хангамжийн лицензийн хугацаа дууссан байна.

Программ хангамжийн бүртгэл, лицензийн мэдээлэл, ашиглалтын байдал нь бүрэн системчлэгдээгүй байна. Тухайлбал, ашиглагдаж буй нийт программ хангамжаас 14 программ хангамжийг нягтлан бодох бүртгэлд биет бус хөрөнгө хэлбэрээр бүртгэсэн, харин 10 программ хангамж санхүүгийн бүртгэлд тусгагдаагүй байна. Мөн 6 программ хангамжийн худалдан авалтын өртөг болон ашиглалтын хугацааны мэдээлэл бүрэн бүртгэгдээгүй байгаа нь программ хангамжийн бодит ашиглалт болон санхүүгийн тайлангийн бүртгэлийн уялдаа хангалтгүй байна.

Мөн программ хангамжийн ашиглалт, лицензийн удирдлагын талаар төвлөрсөн хяналтын тогтолцоо хангалттай бүрдээгүй байна. Судалгаагаар 3 программ хангамж ашиглалтгүй боловч бүртгэлээс хасагдаагүй, 2 программ хангамжийн лицензийн хугацаа дууссан, 5 программ хангамжид шинэчлэлт, засвар үйлчилгээ тогтмол хийгдээгүй байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Эрдэнэс тавантолгой ХК-ын төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 22 дугаар тогтоолын хавсралтаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн дараах байдлаар баталсан байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалт төсөвт өртөг 1,270,179.6 сая төгрөгөөр төлөвлөж тайлант онд санхүүжих дүн нь 417,251.6 сая төгрөг;
- Үйл ажиллагааны төсөвт өртөг 4,061,731.5 сая төгрөгөөр төлөвлөж тайлант онд санхүүжих дүн нь 2,378,568.0 сая төгрөг;

Гүйцэтгэлээр 322 гэрээний 699,402.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс 306,145.5 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч төлөвлөгөөний хэрэгжилт 43.7 хувийн биелэлттэй, барилга байгууламжийн ажил гүйцэтгэх 18 гэрээний 19,417.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс 12,330.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Эрдэнэс Тавантолгой ХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах компанийн засаглал, дотоод хяналт, үйл ажиллагааны оновчлол, санхүүгийн сахилга бат болон мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор М.Ганбаатар, Я.Марал-Эрдэнэ нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Эрдэнэс Тавантолгой ХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01/325 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасан аргачлалын дагуу тодорхойлж, материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн **нийт хөрөнгийн дүнг** сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг **их** гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 24,049,980.5 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 120,249.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн 50 болон түүнээс дээш хувийн оролцоотой хуулийн этгээдүүдэд хамаарах зохицуулалтыг мөрдөх шаардлагатай бөгөөд уг хуулийн 3.1.4-т зааснаар төрийн өмчийн оролцоотой компанийн удирдлага, албан тушаалтнууд хуулийн үйлчлэх хүрээнд багтдаг. Үүний дагуу удирдлагын бүтэц, орон тоо, албан томилолт, урамшуулал, худалдан авах ажиллагаа, санхүүгийн тайлагнал болон ил тод байдлын зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд эдгээр нь байгууллагын санхүүгийн сахилга бат, зардлын үр ашигтай зарцуулалтыг хангах зорилготой.

Компанийн зүгээс тайлант хугацаанд дээрх зохицуулалтын хүрээнд албан томилолтын зардлыг хуулийн шаардлагад нийцүүлэн зохицуулах, ажлын хэсэг, зөвлөл, комиссын гишүүдэд үндсэн цалингаас гадуур урамшуулал олгохгүй байх, худалдан авах ажиллагааны мэдээллийг цахим системд байршуулж ил тод байдлыг хангах, мөн санхүүгийн тайлан болон холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудсаар олон нийтэд нээлттэй мэдээлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд шаардлагатай мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд бүрэн байршуулсан нь тогтоогдсон тул Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зохистой гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 3,475,010.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 албан шаардлага, 9 зөвлөмж өглөө. Үүнд:

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Эрдэнэс Тавантолгой ХК нь банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэсгүй боловч Засгийн газрын шийдвэрээр Багануур ХК, Шивээ-Овоо ХК, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, Тавантолгой төмөр зам ХХК, Монголын төмөр зам ТӨХК-уудад урт хугацаатай зээл олгож, нийт 918,021.9 сая төгрөгийн эргэн төлөлтийн эрсдэлтэй зээлийн авлага үүсгэсэн нь компанийн үйл ажиллагааны чиглэл, хууль эрх зүйн зохицуулалт, санхүүгийн сахилга бат болон засаглалын зарчимд үл нийцсэн, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчсөн байна. Тухайлбал:

1. Компанийн санхүүгийн тогтвортой байдалд өндөр эрсдэл бий болгосон:

Эрх зүйн үндэсгүй олгосон зээлийн багц нь эргэн төлөлтийн эрсдэл өндөртэй, компанийн мөнгөн урсгалыг хумих, үндсэн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг хойшлуулах, өрийн дарамтыг хүндрүүлэх сөрөг үр дагавар үүсгэж, компанийн санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл бий болгосон.

2. Хувьцаа эзэмшигчдийн өмчийн эрхийг зөрчсөн байдал: Зээл олголт нь компанийн үндсэн зорилго, бизнесийн үйл ажиллагаанд хамааралгүй бөгөөд 3 сая хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг бууруулах, хөрөнгө оруулалтын боломжийг хязгаарлах, эрсдэлийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх зэрэг байдлаар хувьцаа эзэмшигчдийн өмчийн эрхийг зөрчсөн байна.

Энэ нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "банк бус санхүүгийн үйл ажиллагаа" гэж Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн эрхэлж байгаа энэ хуулийн 7.1.-д заасан үйлчилгээг", 6 дугаар зүйлийн 6.1-т "Банк бус санхүүгийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд эрхэлж болно", 7 дугаар зүйлийн 7.1.1-д "зээл" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд нийцээгүй урт хугацаат зээлийг олгосноос үүдэн эргэн төлөлтийн эрсдэл бүхий зээлийн авлага үүсгэсэн зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Компанийн үндсэн чиг үүргээс гадуурх улс орны стратегийн дэд бүтцийн томоохон төслүүд болох Богдхан төмөр зам болон газрын тос дамжуулах хоолойн нийт 1,122.6 сая ам.долларын санхүүжилтийг Эрдэнэс Тавантолгой ХК-д хариуцуулсан нь байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, засаглалын зарчим болон хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчиж, холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцэхгүй шийдвэр гаргасан байна. Үүнд:

1. Богдхан төмөр зам төсөл – 734.6 сая ам.долларын санхүүжилт

Засгийн газрын 2021 оны 206 дугаар тогтоолоор компанид зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын нийт санхүүжилтийг хариуцуулсан. Үүний дагуу байгуулсан МН-ЭТТ-2022/487, ТТЗ-МН22/01, ВІ-ВВR-СОНТ-0002 дугаар гэрээнүүдээр нийт 734.6 сая ам.долларын үүрэг хүлээж 130,551.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

2. Газрын тос дамжуулах хоолойн төсөл – 388.0 сая ам.долларын санхүүжилт

УУХҮЯ-ны олон улсын нээлттэй тендерийн үр дүнд БНХАУ-ын төрийн өмчит "Норинко Интернэшнл Кооперэйшн" компани ЕРС гүйцэтгэгчээр сонгогдож, санхүүжилтийн 388.0 сая ам.долларыг Эрдэнэс тавантолгой ХК дангаар хариуцах зохицуулалт хийгдэж 912,146.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Энэ нь Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-т "Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ: ...",

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах" гэж заасныг, 21 дүгээр зүйлийн 21-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн үндсэн чиг үүргээс гадуурх нийгмийн шинж чанартай төслийг санхүүжүүлж, байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, засаглалын зарчим болон хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчиж, холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцэхгүй шийдвэр гаргасан зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Монгол Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар "Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай" тогтоолоор "Тавантолгой түлш" ХХК-ийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэхдээ хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх үүргийг Засгийн газарт үүрэг болгосон бөгөөд Засгийн газрын 2025 оны 18 дугаар тогтоолоор өр, авлагыг шийдвэрлэх үүргийг Эрдэнэс Тавантолгой ХК-д үүрэг болгосон боловч Тавантолгой түлш ХХК-ийн 1,366,306.1 сая өр төлбөр, 2,154.5 сая төгрөгийн авлагыг эцэслэн шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-т "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 18 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Компанийн энгийн хувьцааны 26.4 хувийг эзэмшигч Монгол Улсын иргэдийн хувьд нас баралт, харьяаллын өөрчлөлт, өв залгамжлалтай холбоотойгоор хувьцааны шилжилт, эрхийн хэрэгжилтийг хэрхэн зохицуулах талаарх эрх зүйн нарийвчилсан зохицуулалтгүй, эрх бүхий байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна. Өмчлөх эрхийн ийм тодорхой бус байдал болон данс байхгүй холбоо тогтоох боломжгүй байдал зэрэг нь ногдол ашиг тараах үйл явцад шууд нөлөөлж 2019–2024 онд зарласан ногдол ашгаас давхардсан тоогоор 1,286,217 иргэн, 1,254 аж ахуйн нэгжид хамаарах нийт 145,205.4 сая төгрөг өнөөг хүртэл тараагдалгүй Сангийн яамны Төрийн сангийн дансанд байршиж байна. Компанийн санхүүгийн тайланд өр төлбөр тусгасан зүйлгүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.13-т "Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн энгийн хувьцааны 26.4 хувийг эзэмшигч Монгол Улсын иргэдийн хувьд нас баралт, харьяаллын өөрчлөлт, өв залгамжлалтай холбоотойгоор хувьцааны шилжилт, эрхийн хэрэгжилт, бүртгэлийн асуудлыг хэрхэн зохицуулах талаарх эрх зүйн нарийвчилсан зохицуулалттай болох саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх талаар албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Эрдэнэс тавантолгой ХК нь уурхайн үйл ажиллагааны явцад үүсдэг хоёрдогч түүхий эд болох ашиглалтаас гарсан дугуй, кабель, зэс эд анги, металл хаягдал, тос, тосолгооны материал, багаж, эд ангиудын ашиглах боломжтой хэсэг зэрэг эд хөрөнгийг хүлээн

авах, бүртгэх, хадгалах, үнэлэх, борлуулж орлого бүртгэх талаар зохицуулсан дотоод журам, бодлого байхгүй байна. Эдгээр бараа, материалын менежмент системтэй явагдаагүй, зарлага гаргаж компаниудад нийлүүлсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Уурхайн үйл ажиллагааны явцад үүсдэг хоёрдогч түүхий эд болох ашиглалтаас гарсан дугуй, кабель, зэс эд анги, металл хаягдал, тос, тосолгооны материал, багаж, эд ангиудын ашиглах боломжтой хэсэг зэрэг эд хөрөнгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, үнэлэх, борлуулж орлого бүртгэх талаар зохицуулсан дотоод журам, бодлого байхгүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 6: Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны Б/94, Б/96, Б/124 дүгээр тушаалаар Хяналтын менежер, Бүтээмжийн менежер, Бизнес хөгжил хариуцсан менежерийн албан тушаалуудыг шинээр бий болгож, эдгээрийн үндсэн цалинг компанийн цалингийн шатлалын G7–G8 түвшинд (12.5–14.0 сая төгрөг) тогтоон тайлант онд нийт 624.3 сая төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Гэвч дээрх албан тушаалуудад тавигдах ажлын байрны шаардлага, үндсэн зорилго, чиг үүрэг, гүйцэтгэлийн хариуцлагын хүрээ бүрэн тодорхойлогдоогүй, байгууллагын бүтэц дэх байр суурь, эрх, хариуцлагын уялдаа тогтоогдоогүй байхад томилгоо хийгдсэн байна.

Мөн Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн багийн ахлагчийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/352 дугаар тушаалаар төв оффисын ажлын байрны нэршил, орон тоог шинэчлэн баталсан боловч дээрх албан тушаалуудын чиг үүрэг, хариуцлагын хуваарилалтыг нэг мөр тодорхой болгоогүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т "Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно", 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.2.чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох"; гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага болон Засгийн газрын хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Төв болон салбарын бүтэц зохион байгуулалт, чиг үүргийн уялдааг шалгахад компанийн засаглал, дотоод хяналт, төлөвлөлт ба гүйцэтгэлийн удирдлагад тавигдах хууль, дотоод журмын шаардлага хангагдаагүй, чиг үүргийн зааглал, хяналтын механизм, орон тооны зохицуулалт нь нэгдмэл байдлаа алдаж, байгууллагын үйл ажиллагаа хэсэгчилсэн, давхардсан бүтэцтэй болсон байна. Ийм нөхцөл байдал нь шийдвэр гаргалт, тайлагнал, хяналт-шинжилгээ болон үйл ажиллагааны нийт үр ашигт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тухайлбал:

1. Чиг үүргийн давхардал их, бүтэц системийн хувьд хэт задралтай байна

Шинжилгээгээр хяналт-аудит-эрсдэлийн чиглэлийн 6 хүртэл нэгж зэрэгцэн ажиллаж, тээвэр-логистик-ачилт-экспортын чиглэлд төв болон салбарын түвшинд дөрвөн өөр удирдлагын төв зэрэгцэн оршиж буй нь байгууллагын гол үйл ажиллагаанд зохион байгуулалтын хүндрэл, давхардсан ачаалал бий болгож, мэдээллийн зөрүү, хэт төвлөрсөн зардал, хяналтын цоорхойг нэмэгдүүлж байна.

Мөн стратеги–төлөвлөлт–төсөл боловсруулах чиг үүрэг салбарын инженерийн нэгжүүдтэй уялдаагүй, хоёр түвшний параллель төлөвлөлт үүссэн нь төсөл хэрэгжилтийн хугацаа алдагдах, өртөг өсөх шалтгаан болж байна.

2. Хяналтын тогтолцоо олон төвтэй, COSO-гийн зарчим алдагдсан байна

COSO-ийн хяналтын загвараар дотоод хяналт нэг төвтэй, нэгдмэл удирдлагатай байх шаардлагатай. Гэтэл компанид хяналтын чиглэл дараах нэгжид тарамдсан байна. Үүнд: Дотоод аудитын алба, Дотоод хяналтын нэгж, Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэсэг, Эрсдэлийн удирдлагын нэгж, Салбарын хяналтын инженерүүд.

Эдгээр нэгжүүдийн хооронд уялдаа холбоо сул, чиг үүргийн зааг тодорхойгүй байгаа нь компанийн хяналтын тогтолцоог нэгдмэл, төвлөрсөн байдлаа алдуулж, үйл ажиллагаа нь жижиг хэсгүүдэд хуваагдан, харилцан уялдаагүй, давхардсан болон зөрчилтэй хэлбэрээр хэрэгжих нөхцөл бүрдүүлж, улмаар хяналтын үр нөлөөг мэдэгдэхүйц бууруулж байна.

3. Орон тоо тэнцвэргүй, үйл ажиллагааны зохион байгуулалт үр ашиггүй байна

Салбарын нийт 616 орон тооны 52.0 хувь нь логистик, тээвэр, ачих-шалгах чиглэлд төвлөрсөн боловч эдгээр нэгжийг шаардлагагүйгээр хэт олон жижиг хэсэг болгон задлуулсан байна.

Энэ нь: удирдлагын шат олон болох, шийдвэр гаргалтын урсгал удаашрах, нэгж бүр өөрийн тайлагнал, ажиллах аргачлалтай болох эрсдэлтэй. Үүнээс шалтгаалан үйл ажиллагааны зардлыг өсгөх, үр ашиг бууруулах хүчин зүйл болж байна.

4. Стратегийн түвшин ба үйлдвэрлэлийн гүйцэтгэл хоорондын уялдаа сул байна

Төвийн стратеги, бодлого боловсруулах чиг үүрэг салбарын уул уурхайн үйлдвэрлэлийн бодит төлөвлөлттэй уялдахгүй, мэдээллийн солилцоо тасалдсан түвшинд байна.

Үүний улмаас: олборлолт–ачилт–тээвэрлэлтийн гүйцэтгэл хоцрох, хүчин чадлын төлөвлөлт оновчгүй байх, үйлдвэрлэлийн эрсдэлийн удирдлага сулрах зэрэг гүйцэтгэлийн доголдол системийн түвшинд үүсэхээр байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгана: 2/ эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин, 5/ менежментийн бодлого", Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын бүтэц, чиг үүргийг иж бүрэн дахин үнэлж, давхардсан нэгжүүдийг нэгтгэн, хариуцлага, зааглал, дотоод журмыг тодорхой болгох, мөн дотоод аудит, хяналт, эрсдэлийн удирдлагыг уялдуулсан нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, төлөвлөлт, нөөцийн хуваарилалт, мэдээллийн урсгалыг оновчтой болгох замаар удирдлага, хяналт, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах.

Илрүүлэлт 2: Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2025 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан Шинэ суурьшлын бүсийн гол төслүүд болох гидрогеологийн иж бүрэн судалгаа, сургууль-цэцэрлэгийн барилгын зураг төсөл, гадна инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалт нь санхүүжилт танагдсан болон бэлтгэл ажил эхлээгүй шалтгаанаар бүгд хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шинэ суурьшлын бүсийн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцоолон баталгаажуулж, төслийн бэлтгэл, хэрэгжилтийг хугацаанд нь эхлүүлэн гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, мөн төслийн эрэмбэ, ач холбогдолд тулгуурлан үе шаттай хэрэгжүүлж, санхүүжилтийн тасалдлын эрсдэлийг бууруулах төлөвлөлт хийж, хяналт-шинжилгээ, тайлагналын тогтолцоог тогтмол хэрэгжүүлэх.

Илрүүлэлт 3: Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн багийн ахлагчийн 2025 оны А/352 дугаар тушаалаар компанийн салбарын ажлын байрны нэр, орон тооны бүтэц шинэчлэн батлагдаж, нийт 2,045 орон тоо тогтоогдсон байна. Гэвч уурхайн салбарын орон сууц, амрах байрны дэд бүтцийн хүчин чадал нэг ээлжинд 799 ажилтан хүлээн

авах боломжтой бөгөөд энэ шийдвэр нь батлагдсан орон тоо болон ээлжийн зохион байгуулалтын хэрэгцээтэй уялдаагүй, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, MNS стандартын шаардлага хангаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгана: 2/ эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин, 5/ менежментийн бодлого", Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн орон тоо, уурхайн дэд бүтцийн хүчин чадлын уялдааг хангах зорилгоор ажлын байрны төлөвлөлт, ээлжийн зохион байгуулалтыг бодит нөхцөлд нийцүүлэн дахин үнэлж, орон сууц, амрах байрны багтаамжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, мөн ХАБЭА-ийн хууль, MNS стандартын шаардлагад нийцүүлэн ажилтны байрлах орчин, хөдөлмөрийн нөхцөлд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг тогтмол хянах.

Илрүүлэлт 4: Нүүрс тээврийн ачих логистикийн төвийн төслийн ажил зүгшрүүлэлтийн шатанд хэрэгжиж байгаатай холбогдуулан овоолго үүсгэх, ачих ажиллагаа тасралтгүй горимоор ажиллахгүй байгаа нь ЦЭХ-ийн хэрэглээг нэмэгдүүлж, ТЭЗҮ-д зааснаас 39.8 хувиар илүү цахилгаан эрчим хүч хэрэглэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нүүрс тээврийн ачих логистикийн төвийн үйл ажиллагааг тасралтгүй горимд шилжүүлж, овоолго болон ачих процессын технологийн зохион байгуулалтыг оновчлон цахилгаан эрчим хүчний илүүдэл хэрэглээг бууруулах, мөн ТЭЗҮ-д тусгагдсан хэрэглээний нормын гүйцэтгэлийг тогтмол хянаж, эрчим хүчний менежментийн тогтолцоог нэвтрүүлэн зүгшрүүлэлтийн үе шатанд үүсэж буй алдагдал, үр ашиггүй хэрэглээг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

Илрүүлэлт 5: Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоонд шаардлагатай үндсэн хамгаалалтын бүрэлдэхүүнүүд (DLP, SIEM, PAM, AV/EDR, Patch/Vulnerability Scanning) бүрэн хэрэгжээгүй, бодлогын баримт бичгийн уялдаа сул, эрхийн удирдлагын зохицуулалт төлөвшөөгүй байна. Нууц үгийн бодлого олон улсын стандартын түвшинд нийцээгүй, эрхийн түвшин хянах, баталгаажуулах процесс (PAM/Password Vault) байхгүй, инсайдер халдлага илрүүлэх хяналтын механизм бүрдээгүй, нөөцлөлт болон сэргээн босголтын үйл ажиллагаа байгууллагын тасралтгүй ажиллагааны шаардлагыг хангахгүй байна.

Үүсэх эрсдэл:

- Мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмж алдагдах бодит эрсдэлтэй.
- Хорлонтой програм, халдлага илрэхгүй үлдэх, системийн эвдрэл бизнесийн тасалдахад хүрэх боломжтой.
- Эрх бүхий хандалтын хяналтгүй байдлаас шалтгаалан дотоод болон гадаад халдлага өргөжин тэлэх эрсдэл өндөр.

Энэ нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т "кибер аюулгүй байдлыг хангах техник, технологийн арга хэмжээ", 19.2.7-д "мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай удирдлага, зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх", 19.2.8-д "кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, бүртгэх, таслан зогсоох мэдээллийн системтэй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог ISO/IEC 27001 стандартад нийцүүлэн DLP, SIEM, PAM, AV/EDR, эмзэг байдлын скан зэрэг хамгаалалтын шийдлүүдийг үе шаттай нэвтрүүлж, бодлогын уялдаа, хэрэгжилт болон эрхийн удирдлагын

нэгдсэн зохицуулалтыг бүрдүүлэх, мөн нууц үгийн бодлого, эрхийн хяналт, баталгаажуулалтыг сайжруулж, инсайдер эрсдэлийн хяналт, нөөцлөлт, сэргээн босголтын (BCP/DRP) төлөвлөгөөг боловсруулан тогтмол турших замаар тасралтгүй ажиллагааг хангах.

Илрүүлэлт 6: Үйлдвэрлэлийн болон хөгжүүлэлтийн орчинд ашиглагдаж буй сервер, өгөгдлийн сан болон аппликейшнүүд хуучирсан, дэмжлэггүй хувилбартай (Windows Server 2008 R2, SMBv1 идэвхтэй, SQL Server 2012 RTM) ажиллаж байгаа нь олон улсын CVE мэдээллийн сангаас өндөр эрсдэлтэй ангилагдсан эмзэг байдлуудад өртөх нөхцөл бүрдүүлж байна. Вэб аппликейшнүүдийн хандалтын хяналт хангалтгүй, security header-ууд (CSP, HSTS, X-Frame-Options, X-Content-Type-Options) бүрэн хэрэгжээгүй, файл upload хамгаалалтын шалгуур сул байна.

Энэ нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т “кибер аюулгүй байдлыг хангах техник, технологийн арга хэмжээ”, 17.1.8-д “шинээр нэвтрүүлсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон тэдгээрийн өөрчлөлт, шинэчлэл бүрд кибер аюулгүй байдлын холбогдох шалгалт хийсэн байх”, 19.2.3-д “мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар стандартыг нэвтрүүлэх”, 19.2.7-д “мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай удирдлага, зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрлэлийн болон хөгжүүлэлтийн орчинд ашиглагдаж буй сервер, өгөгдлийн сан, аппликейшнүүдийг дэмжлэгтэй, аюулгүй байдлын шинэчлэлт тогтмол хийгддэг хувилбар руу үе шаттайгаар шилжүүлж, мөн вэб аппликейшний аюулгүй байдлыг сайжруулан хандалтын хяналтыг бэхжүүлэх, вэбийн аюулгүй байдлын толгой тохиргоог бүрэн хэрэгжүүлэх, файл байршуулах үйлдэлд аюулгүй байдлын шалгуур нэвтрүүлэх.

Илрүүлэлт 7: Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг шинээр сонгон шалгаруулахдаа Төрийн өмч, бодлого зохицуулалтын газрын цахим хуудсаар олон нийтэд зарлан мэдээлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.4-т "Хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах тухай зарыг 5-аас доошгүй өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тухайн компанийн цахим хуудсаар нийтэд зарлан мэдээлнэ.", ЭТТ ХК-ийн дүрмийн 3.3.4-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн болон төрийг төлөөлөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний 2/3-ийг нээлттэй зарлан сонгон шалгаруулна" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй, өрсөлдөөнт байдлаар зохион байгуулах, тухайлбал Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй зарлан мэдээлж, нэр дэвшигчдийг тэгш боломжтой оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх.

Илрүүлэлт 8: Компанийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, мөнгөн урсгалын төлөв байдлыг иж бүрэн үнэлж шийдвэрлээгүй байхад Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2024 оны олсон ашгаас иргэдэд ногдол ашиг хуваарилах асуудлыг Монгол Улсын Засгийн газар-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 225 дугаар тогтоолоор шийдвэрлэж, компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны гүйцэтгэлд үндэслэн 2024 оны цэвэр ашгийн зохих хувийг хуульд заасны дагуу ногдол ашиг хэлбэрээр иргэдэд хуваарилах арга хэмжээ авахыг даалгасан байна.

Уг тогтоолыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Ногдол ашиг хуваарилах тухай” 03 дугаар тогтоолоор нэгж хувьцаанд 326.5 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар /төрд 2,879.8 тэрбум төгрөг, аж ахуйн нэгжид 2.3 тэрбум төгрөг, иргэдэд 1,035.9 тэрбум төгрөг/ шийдвэрлэсэн нь компанийн санхүүгийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын эх үүсвэр болон мөнгөн урсгалын удирдлагад эрсдэл үүсгэхүйц өндөр түвшинд тогтоогдсон байна..

Энэ нь Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1-д "ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх",

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалт, журмын 3 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.

ТУЗ-ийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Эрдэнэс тавантолгой Хувьцаат компанийн ногдол ашгийн бодлого"-ын 2.4-т "Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татвар төлсний дараах цэвэр ашгийн хэмжээ, компанийн богино болон дунд хугагацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөл тогтооно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, компанийн дүрэм болон “Ногдол ашгийн бодлого”-д заасан шаардлагыг хангаж, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг гаргахдаа компанийн төлбөрийн чадвар, мөнгөн урсгалын тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, стратегийн төлөвлөгөөтэй уялдуулан иж бүрэн санхүүгийн үнэлгээнд үндэслэх;

Ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргахын өмнө санхүүгийн чадавх, эрсдэлийн үнэлгээ, мөнгөн урсгалын төсөөллийг баримтжуулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, шийдвэр гаргалтын үндэслэл, тооцооллыг нотлох баримтаар баталгаажуулах.

Илрүүлэлт 9: Нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-д хаягдлын далан байгуулахаар төлөвлөсөн боловч газрын ашиглалтын зөвшөөрөл олгогдоогүйгээс шалтгаалан уг байгууламжийг бариагүй, мөн зүгшрүүлэг тохируулгын ажлууд хийгдэж байгаатай холбоотойгоор бүрэн хүчин чадлаар ажиллаагүйгээс нэмэлт зардал гарсан байна. Тухайлбал:

- 2025 онд зүгшрүүлэх, тохируулах үйл ажиллагаа явагдсан ба 1,593.9 мянган тонн тэжээл хүлээн авч, үйлдвэрийн конвейрийн жингээр 1,166.8 мянган тонн баяжмал, 427.1 мянган тн хаягдал үйлдвэрлэсэн байна. Тус хаягдлыг Цанхийн зүүн уурхайн хөрсний 2-р овоолго руу зөөж нэмэлт зардал гаргаж байна.
- Цахилгааны хэрэглээ нь ТЭЗҮ-д заасан утгаас хэлбэлзэлтэй байна. /1 тн бүтээгдэхүүнд зарцуулах ЦЭХ-ний хэрэглээ 7.05 квт/ц-аар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 9.47 квт/ц зарцуулсан/.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1-т "Захирал дараахь эрх, үүрэгтэй: 3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан технологийн горим, төслийн анхны шийдэлтэй нийцүүлэн хэвийн, үр ашигтай түвшинд хүргэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх, үүнд хаягдлын далан байгуулахад шаардлагатай газрын ашиглалтын зөвшөөрлийг холбогдох байгууллагаас шуурхай шийдвэрлүүлж, хаягдлыг түр хугацаанд өөр байршилд зөөвөрлөхөөс үүдэж буй нэмэлт зардлыг бууруулах, зүгшрүүлэг тохируулгын ажлыг бүрэн дуусган үйлдвэрийн хүчин чадал, технологийн үзүүлэлтүүдийг тогтворжуулах, мөн нэгж бүтээгдэхүүнд ногдох цахилгаан эрчим хүчний хэрэглээг ТЭЗҮ-д туссан түвшинд ойртуулах техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулан, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар үнэлж, залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилгуулахаар аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 120,604.4 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 912,817.8 сая төгрөгийн зөрчилд 22 зөвлөмж өгснийг 92.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	13	120,604,386.0	13	120,039,856.3	91.4
2	Зөвлөмж	22	912,817,822.3	22	912,817,822.2	94.1
	Нийт дүн	35	1,033,422,208.3	35	1,032,857,678.5	92.7

Өмнөх аудитаар компанийн бүтэц, зохион байгуулалттай уялдаагүйгээр чиг үүрэг давхардуулан томилгоо хийсэн зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн албан шаардлага хэрэгжээгүй байна. Иймд уг асуудлын шийдвэрлэх албан шаардлагыг Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг авч үзэн, нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолоор Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны 20 хүртэлх хувийг, 2018 оны 73 дугаар тогтоолоор Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалахаар шийдвэрлэсэн. Тус шийдвэрийн дагуу Засгийн газрын хуралдаанаас Эрдэнэс Тавантолгой ХК-ийг нээлттэй хувьцаат компани болгох чиглэлээр удаа дараа үүрэг даалгавар өгсөн бөгөөд Эрдэнэс Тавантолгой ХК-ийг нээлттэй хувьцаат компани болгох бэлтгэл ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн байна.
- Эрдэнэс Тавантолгой ХК гадаадын хөрөнгийн биржид IPO гаргах үед тулгарч болзошгүй хамгийн том эрсдэл нь хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй холбоотой асуудлууд юм. Одоогоор 3.4 сая иргэн нийт хувьцааны 26.4 хувийг эзэмшдэг нь олон улсын хөрөнгө оруулагчдын хувьд зохион байгуулалтын өндөр эрсдэл гэж тооцогддог. Ийм олон хувьцаа эзэмшигчийн мэдээллийг IFRS, ESG зэрэг олон улсын стандартад нийцүүлэн бүртгэх, баталгаажуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал болон санал авах ажиллагааг зохион байгуулах, ногдол ашиг тараах зэрэг корпорацийн засаглалын процессыг хэрэгжүүлэхэд хүндрэлүүд бий болно. Мөн иргэдийн хувьцаа нээгдсэн тохиолдолд богино хугацаанд их хэмжээний хувьцаа зах зээлд гарах нь IPO-ийн дараах үнийн огцом уналтын эрсдэлийг нэмэгдүүлнэ.
- Үүнээс гадна гадаадын биржүүдийн хатуу шаардлага болох олон улсын аудит, санхүүгийн ил тод байдал, засаглалын шинэ бүтэц, төрийн оролцоог бууруулах зэрэг шалгуур нь компанид бодит дарамт үүсгэх магадлалтай. Төрийн өмч давамгайлсан бүтэц, бодлогын тогтворгүй байдал, лицензийн болон нүүрсний зах зээлийн савлагаатай холбоотой эрсдэлийг олон улсын хөрөнгө оруулагчид өндөр үнэлдэг тул эдгээр асуудалд тодорхой, тогтвортой шийдэлгүй бол компанийн үнэлгээ буурах, хөрөнгө оруулагчдын сонирхол сулрах эрсдэлтэй.
- Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг Засгийн газар тогтоохоор хуульчлагдсан боловч тус жишгийг батлан гаргаагүйгээс Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны “Төв оффисын цалингийн сүлжээг шинэчлэн батлах тухай” А/466 дугаар, “Салбарын цалингийн сүлжээг шинэчлэн батлах тухай” А/467 дугаар тушаалаар компанийн нийт ажилтны цалингийн сүлжээг шинэчлэн баталсан байна.
- Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 30 дугаар тэмдэглэлээр Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төв оффисыг үйл ажиллагаа явуулж буй орон нутагт шилжүүлэх талаар санал боловсруулж танилцуулах үүргийг УУХҮЯ, ТӨБЗГ болон “Эрдэнэс Монгол” ХХК-д өгсөн боловч “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьд уг чиглэлийн хүрээнд тодорхой шийдэл, бодит үр дүн гаргаагүй байна. Төв оффисыг шилжүүлээгүй хэвээр байгаагаас үүдэн Чимо ХХК-аас оффисын байр түрээслэн ашиглаж, тайлант хугацаанд нийт 1,396.3 сая төгрөгийн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар нийт 180.0 сая төгрөгийн түрээсийн зардал гаргасан байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил

Аудитаар нийт 5,278,189.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,338,502.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,939,687.0 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 5,278,189.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 120,249.9 сая төгрөгөөс давсан тул зөрчлийн дүн болон шинж чанарын хувьд материаллаг гэж үзэн “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Монгол Улсын Их Хурлын 2024 оны Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай 10 дугаар тогтоолоор Эрдэнэс Тавантолгой ХК-ийн эрх бүхий байгууллага ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан тохиолдолд төрийн өмчид ногдох ногдол ашгийн орлогоос Эрдэнэс Тавантолгой ХК, “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний нэгдэлд хамаарах, төрийн өмчийн оролцоотой бусад аж ахуйн нэгжүүдийн хооронд үүссэн өр, авлагыг суутган тооцохоор зохицуулсан. Гэвч энэхүү зохицуулалт бодитоор хэрэгжээгүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу 2022–2023 оны төрд ногдох ногдол ашгийн 3,305,196.7 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

Энэ нь УИХ-ын 2024 оны 10 дугаар тогтоолын 3-т /“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн эрх бүхий этгээд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компани, түүний нэгдлийн болон бусад төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хооронд үүссэн өр авлагад суутган тооцох” заалтуудыг биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Их Хурлын 2024 оны Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Эрдэнэс Тавантолгой ХК-аас хэрэгжүүлж буй “Сая тонн – Сая мод” хөтөлбөрийн дагуу батлагдсан ТЭЗҮ-ийн үндсэн дээр улс, орон нутгийн хэмжээнд мод үржүүлгийн газар байгуулах, мод бут тарих, арчлан ургуулах зорилгоор Онцгой байдлын ерөнхий газартай 2022 онд байгуулсан ЭТТ-2022/503 дугаар бүхий “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 27,500.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн боловч гэрээний үр дүнг дүгнээгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-д “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 211 дүгээр зүйлийн 211.1-д “Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Онцгой байдлын ерөнхий газартай 2022 онд байгуулсан ЭТТ-2022/503 дугаар бүхий “Хамтран ажиллах гэрээ”-ний үр дүнг дүгнээгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Тус байгууллагаас бэлтгэн нийлүүлэгчидтэй байгуулсан зарим гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул байгаагаас гэрээний хугацаа хэтэрсэн,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нийлүүлэх бараа материалыг хүлээн аваагүй, ажил үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэж гэрээг хаагаагүй зөрчил илэрч байна. Тухайлбал:

- “Хуа Еэ Интернэйшнл” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/300 тоот XCMG-XDE240 автосамосвалын сэлбэг эд анги нийлүүлэх гэрээний хэрэгжилт 97–235 хоногоор хоцорч, 383.1 сая төгрөгийн нийлүүлэлт хийгдээгүй;
- “Хьюндэй Автос” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/264 тоот XCMG XDE130 автосамосвалын сэлбэг эд анги нийлүүлэх гэрээний 3.7 сая төгрөгийн бараа материалыг хүлээн аваагүй;
- “Элит Рийч Зи Зи Ай” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/616 тоот XCMG XDE130 автосамосвалын сэлбэг эд анги нийлүүлэх гэрээний 5,303.3 сая төгрөгийн бараа материалыг хүлээн аваагүй;
- “Арбэл Алтай” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/313, ЭТТ-2025/313-01 тоот Цанхийн баруун уурхайн хөрсний 1, 2 дугаар овоолго дээрх дахин дамжуулах станцын гадна цахилгаан хангамжийн зураг төсөл боловсруулах гэрээний нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 18.7 сая төгрөгийн ажил үйлчилгээ хугацаа хэтэрсэн;
- “Зууны хөгжлийн зам” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/458 тоот 8.2 км авто замд байрлах нүхэн гарцын ухмалын хажуу налуугийн бэхэлгээний зураг төсөл боловсруулах 19.4 сая төгрөгийн ажил үйлчилгээ хугацаа хэтэрсэн;
- “Голомт өргөө” ХХК-тай байгуулсан ЭТТ-2020/189 тоот уурхайн ажилчдын хотхоны барилгын ажлын явцад зураг төсөл зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний гэрээний 77.5 сая төгрөгийн ажил үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэж, гэрээг хаагаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-д “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 211 дүгээр зүйлийн 211.1-д “Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлтгэн нийлүүлэгчидтэй байгуулсан зарим гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул байгаагаас гэрээний хугацаа хэтэрсэн, нийлүүлэх бараа материалыг хүлээн аваагүй, ажил үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэж гэрээг хаагаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгө, хөрөнгө оруулалтын бүртгэл ба үнэлгээний зөрчил

“Тавантолгой Төмөр зам” ХХК-ийн 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 1 дүгээр тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолын дагуу Эрдэнэс Тавантолгой ХК нь тус компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч болж, нийт 816,191.9 мянган ширхэг хувьцааг 2,040,479.8 сая төгрөгийн үнэлгээгээр эзэмшсэн байна.

Мөн Эрдэнэс Тавантолгой ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Бодь Интернэшнл” ХХК-ийн хооронд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан “Тавантолгой–Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээ”-ний 4.1-т, хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ”-нд заасны дагуу төслийн санхүүжилтийг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн “Тавантолгой төмөр зам” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтад тооцож, хувьцаанд хөрвүүлэхээр зохицуулсан байна.

Гэвч Эрдэнэс Тавантолгой ХК-аас төслийн санхүүжилтэд олгосон нийт 3,283,903.7 сая төгрөгөөс 1,346,716.6 сая төгрөгийг хувьцаанд хөрвүүлсэн бөгөөд үлдсэн 1,937,187.0 сая төгрөгийг гэрээний дээрх заалтын дагуу хувьцаанд бүрэн хөрвүүлээгүй, "урьдчилгаа" дансанд үлдэгдлээр бүртгэж байгаа нь гэрээний заалт зөрчигдсөн байна.

Энэ нь Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрдэнэс Тавантолгой ХК нь "Тавантолгой төмөр зам" ХХК-д олгосон төслийн санхүүжилтийг холбогдох гэрээ, хувьцаа эзэмшигчдийн шийдвэрт нийцүүлэн бүрэн хэмжээгээр хувьцаанд хөрвүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2. Бараа материалын бүртгэл, үнэлгээ ба нөөцийн хангалтын зөрчил

Эрдэнэс Тавантолгой ХК нь уурхайн үйлдвэрлэлийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангахад шаардлагатай стратегийн ач холбогдол бүхий бараа материал, сэлбэг хэрэгслийн нөөцийг эрсдэлийн удирдлагад суурилан зохистой түвшинд төлөвлөж, бүрдүүлээгүй нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд доголдол үүсэх, зогсолт бий болох эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрдэнэс Тавантолгой ХК нь уурхайн үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор стратегийн ач холбогдол бүхий бараа материал, сэлбэг хэрэгслийн нөөцийг эрсдэлийн удирдлагад суурилан оновчтой түвшинд тодорхойлж, нөөцийн доод, дээд хэмжээг тогтоон мөрдүүлэх, хэрэгцээний төлөвлөлтийг үйлдвэрлэлийн төлөвлөгөөтэй уялдуулахын зэрэгцээ нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалт, хяналтын тогтолцоог сайжруулж, үйлдвэрлэлийн зогсолт, доголдлын эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

3. Зардал, цалин хөлсний бүртгэлтэй холбоотой зөрчил

3.1. Салбарын ажилтнуудын цагийн бүртгэлийг цахимжуулах ажлыг 2025 оноос эхлүүлэн Мэдээлэл, технологи, инновацийн хэлтсийн инженерүүд хариуцан хөгжүүлж байгаа бөгөөд хөгжүүлэлтийн явцад хүний нөөцийн мэргэжилтнүүдээс шаардлагатай мэдээлэл, өгөгдлийг авч, гарч болох бүхий л нөхцөл байдлыг програмчлалд тусгах шаардлагатай болсон байна. Энэ нь цаг хугацаа их шаардсан, бүрэн гүйцэд ажиллагааг хангаагүй тул одоогоор цагийн бүртгэлийг Excel хэлбэрээр гараар бөглөж баталгаажуулж байна.

Ийм зохицуулалт нь цагийн бүртгэлийн үнэн зөв, найдвартай байдал, түүнийг баталгаажуулах хяналтыг сулруулж байгаа бөгөөд бодит ажилласан цагийг буруу бүртгэх эрсдэл бий болгож байна.

Энэ нь Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Эрдэнэс Тавантолгой ХК-ын гүйцэтгэх захирлын 2022 оны "Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай" А/124 тоот тушаалын 6.9, 6.10, 6.12, 6.14, 6.15 гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Салбарын ажилтнуудын цагийн бүртгэлийг бүрэн цахимжуулж, хүний нөөц, цалин хөлсний системтэй уялдсан нэгдсэн шийдлийг богино хугацаанд нэвтрүүлэх, хөгжүүлэлтийн ажлыг шаардлагатай өгөгдөл, бизнесийн шаардлагаар бүрэн ханган гүйцэтгэх, мөн шилжилтийн хугацаанд гараар хөтөлж буй бүртгэлд давхар хяналт, баталгаажуулалтын механизмыг хэрэгжүүлж, цагийн бүртгэлийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах замаар цалин хөлсний зардлын буруу бүртгэлийн эрсдэлийг бууруулах.

3.2. Тайлант онд Бурхан Халдун хайрханы хүндэтгэлийн цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх зорилгоор 2,500.0 сая төгрөгийг Зэвсэгт хүчний Жанжин штаб руу

шилжүүлсэн боловч энэхүү зарцуулалт нь компанийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээ болон батлагдсан төсвийн зориулалттай уялдаагүй, хандив, тусламжийн шинжтэй санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", Үндэсний баялагийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8."Энэ хуулийн 12.4, 12.6-д заасан хуулийн этгээд нь дүрэмд заасан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэхийг хориглоно." Компанийн дүрмийн 1.2.1, 1.2.2, 1.2.3 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн санхүүгийн нөөцийг зарцуулахдаа үндсэн үйл ажиллагааны чиг үүрэг, батлагдсан төсөв болон холбогдох хууль, журмын шаардлагад нийцүүлж, үйл ажиллагааны хүрээнээс хэтэрсэн хандив, тусламжийн шинжтэй санхүүжилт олгохгүй байх, харин тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд Ашигт малтмалын тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд орон нутагтай байгуулсан гэрээ, үүрэг хариуцлагад тулгуурлан нийгмийн шинжтэй арга хэмжээг санхүүжүүлэх, уг шийдвэр гаргалт, зарцуулалтыг баримтжуулж, ил тод, хяналттай хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		Зөвлөмж Дүн
		Дүн		Тоо		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Монгол Улсын Их Хурлын 2024 оны Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай 10 дугаар тогтоолоор Эрдэнэс Тавантолгой ХК-ийн эрх бүхий байгууллага ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан тохиолдолд төрийн өмчид ногдох ногдол ашгийн орлогоос Эрдэнэс Тавантолгой ХК, “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний нэгдэлд хамаарах, төрийн өмчийн оролцоотой бусад аж ахуйн нэгжүүдийн хооронд үүссэн өр, авлагыг суутган тооцооор зохицуулсан. Гэвч энэхүү зохицуулалт бодитоор хэрэгжээгүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу 2022–2023 оны төрд ногдох ногдол ашгийн 3,305,196.7 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.	1	3,305,196.8	1	3,305,196.8	
2	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Эрдэнэс Тавантолгой ХК-аас хэрэгжүүлж буй “Сая тонн – Сая мод” хөтөлбөрийн дагуу батлагдсан ТЭЗҮ-ийн үндсэн дээр улс, орон нутгийн хэмжээнд мод үржүүлгийн газар байгуулах, мод бут тарих, арчлан ургуулах зорилгоор Онцгой байдлын ерөнхий газартай 2022 онд байгуулсан ЭТТ-2022/503 дугаар бүхий “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 27,500.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн боловч гэрээний үр дүнг дүгнээгүй, хэрэгжилт хангалтгүй байна.	1	27,500.0	1	27,500.0	
3	Тайлант онд Бурхан Халдун хайрханы хүндэтгэлийн цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх зорилгоор 2,500.0 сая төгрөгийг Зэвсэгт хүчний Жанжин штаб руу шилжүүлсэн боловч энэхүү зарцуулалт нь компанийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээ болон батлагдсан төсвийн зориулалттай уялдаагүй, хандив, тусламжийн шинжтэй санхүүжилт олгосон байна.	1	2,500.0			2,500.0
4	Тус байгууллагаас бэлтгэн нийлүүлэгчидтэй байгуулсан зарим гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул байгаагаас гэрээний хугацаа хэтрэх, нийлүүлэх бараа материалыг хүлээн аваагүй, ажил үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэж гэрээг хаагаагүй зөрчил илэрч байна. Үүнд: -“Хуа Еэ Интернэйшнл” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/300 тоот XCMG-XDE240 автосамосвалын сэлбэг эд анги нийлүүлэх гэрээний хэрэгжилт 97–235 хоногоор хоцорч, 383.1 сая төгрөгийн нийлүүлэлт хийгдээгүй; -“Хьондэй Автос” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/264 тоот XCMG XDE130 автосамосвалын сэлбэг эд анги нийлүүлэх гэрээний 3.7 сая төгрөгийн бараа материалыг хүлээн аваагүй; -“Элит Рийч Зи Ай” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/616 тоот XCMG XDE130 автосамосвалын сэлбэг эд анги нийлүүлэх гэрээний 5,303.3 сая төгрөгийн бараа материалыг хүлээн аваагүй; -“Арбэл Алтай” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/313, ЭТТ-2025/313-01 тоот Цанхийн баруун уурхайн хөрсний 1, 2 дугаар овоолго дээрх дахин дамжуулах станцын гадна цахилгаан хангамжийн зураг төсөл боловсруулах гэрээний нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 18.7 сая төгрөгийн ажил үйлчилгээ хугацаа хэтэрсэн;	1	5,805.8	1	5,805.8	

/сая төгрөгөөр/

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	<p>-"Зууны хөгжлийн зам" ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/458 тоот 8.2 км авто замд байрлах нүхэн гарцын умгалын хажуу налуугийн бэхлэлтийн зураг төсөл боловсруулах 19.4 сая төгрөгийн ажил үйлчилгээ хугацаа хэтэрсэн;</p> <p>-"Голомт өргөө" ХХК-тай байгуулсан ЭТТ-2020/189 тоот уурхайн ажилчдын хотхоны барилгын ажлын явцад зураг төсөл зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний гэрээний 77.5 сая төгрөгийн ажил үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэж, гэрээг хаагаагүй байна.</p>				
5	<p>"Тавантолгой Төмөр зам" ХХК-ийн 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 1 дүгээр тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолын дагуу Эрдэнэс Тавантолгой ХК нь тус компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч болж, нийт 816,191.9 мянган ширхэг хувьцааг 2,040,479.8 сая төгрөгийн үнэлгээгээр эзэмшсэн байна.</p> <p>Мөн Эрдэнэс Тавантолгой ХК, "Тавантолгой төмөр зам" ХХК болон "Бодь Интернэшл" ХХК-ийн хооронд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээ"-ний 4.1-т, хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаа эзэмшигчдийн гэрээ"-нд заасны дагуу төслийн санхүүжилтийг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн "Тавантолгой төмөр зам" ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтад тооцож, хувьцаанд хөрвүүлэхээр зохицуулсан байна.</p> <p>Гэвч Эрдэнэс Тавантолгой ХК-аас төслийн санхүүжилтэд олгосон нийт 3,283,903.7 сая төгрөгөөс 1,346,716.6 сая төгрөгийг хувьцаанд хөрвүүлсэн бөгөөд үлдсэн 1,937,187.0 сая төгрөгийг гэрээний дээрх заалтын дагуу хувьцаанд бүрэн хөрвүүлээгүй, "урьдчилгаа" дансанд үлдэгдлээр бүртгэж байгаа нь гэрээний заалт зөрчигдсөн байна.</p>	1	1,937,187.0	1	1,937,187.0
6	<p>Эрдэнэс Тавантолгой ХК нь уурхайн үйлдвэрлэлийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангахад шаардлагатай стратегийн ач холбогдол бүхий бараа материал, сэлбэг хэрэгслийн нөөцийг эрсдэлийн удирдлагад суурилан зохистой түвшинд төлөвлөж, бүрдүүлээгүй нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд доголдол үүсэх, зогсолт бий болох эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.</p>	1	-	1	-
7	<p>Салбарын ажилтнуудын цагийн бүртгэлийг цахимжуулах ажлыг 2025 оноос эхлүүлэн Мэдээлэл, технологи, инновацийн хэлтсийн инженерүүд хариуцан хөгжүүлж байгаа бөгөөд хөгжүүлэлтийн явцад хүний нөөцийн мэргэжилтнүүдээс шаардлагатай мэдээлэл, өгөгдлийг авч, гарч болох бүхий л нөхцөл байдлыг програмчлалд тусгах шаардлагатай болсон байна. Энэ нь цаг хугацаа их шаардсан, бүрэн гүйцэд ажиллагааг хангаагүй тул одоогоор цагийн бүртгэлийг Excel хэлбэрээр гараар бөглөж баталгаажуулж байна. Ийм зохицуулалт нь цагийн бүртгэлийн үнэн зөв, найдвартай байдал, түүнийг баталгаажуулах хяналтыг сулруулж байгаа бөгөөд бодит ажилласан цагийг буруу бүртгэх эрсдэл бий болгож байна.</p>	1	-	1	-
	Нийт дүн	7	5,278,189.6	3	3,338,502.6
				4	1,939,687.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				
		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
1	<p>Эрдэнэс Тавантолгой ХК нь банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэсгүй боловч Засгийн газрын шийдвэрээр Багануур ХК, Шивээ-Овоо ХК, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, Тавантолгой төмөр зам ХХК, Монголын төмөр зам ТӨХК-уудад урт хугацаатай зээл олгож, нийт 918,021.9 сая төгрөгийн эргэн төлөлтийн эрсдэлтэй зээлийн авлага үүсгэсэн нь компанийн үйл ажиллагааны чиглэл, хууль эрх зүйн зохицуулалт, санхүүгийн сахилга бат болон засаглалын зарчимд үл нийцсэн, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчсөн байна. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Компанийн санхүүгийн тогтвортой байдалд өндөр эрсдэл бий болгосон Эрх зүйн үндэсгүй олгосон зээлийн багц нь эргэн төлөлтийн эрсдэл өндөртэй, компанийн мөнгөн урсгалыг хумих, үндсэн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг хойшлуулах, балансын бүтэц, өрийн дарамтыг хүндрүүлэх сөрөг үр дагавар үүсгэж, компанийн санхүүгийн тогтвортой байдалд ноцтой эрсдэл бий болгосон. Хувьцаа эзэмшигчдийн өмчийн эрхийг зөрчсөн байдал Зээл олголт нь компанийн үндсэн зорилго, бизнесийн үйл ажиллагаанд хамааралгүй бөгөөд 3 сая хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг бууруулах, хөрөнгө оруулалтын боломжийг хязгаарлах, эрсдэлийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх зэрэг байдлаар хувьцаа эзэмшигчдийн өмчийн эрхийг зөрчсөн байна. <p>Компанийн үндсэн чиг үүргээс гадуурх улс орны стратегийн дэд бүтцийн томоохон төслүүд болох Богдхан төмөр зам болон газрын тос дамжуулах хоолойн нийт 1.122 тэрбум ам.долларын санхүүжилтийг Эрдэнэс Тавантолгой ХК-д хариуцуулсан нь байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, засаглалын зарчим болон хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчиж, холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцэхгүй шийдвэр гаргасан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Богдхан төмөр зам төсөл – 734.6 сая ам.долларын санхүүжилт Засгийн газрын 2021 оны 206 дугаар тогтоолоор компанид зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын нийт санхүүжилтийг хариуцуулсан, Үүний дагуу байгуулсан МН-ЭТТ-2022/487, ТТЗ-МН22/01, ВI-BBR-CONT-0002 дугаар гэрээнүүдээр нийт 734.6 сая ам.долларын үүрэг хүлээж 130.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. 	1	918,021.9	1	918,021.9			
2	<p>Компанийн үндсэн чиг үүргээс гадуурх улс орны стратегийн дэд бүтцийн томоохон төслүүд болох Богдхан төмөр зам болон газрын тос дамжуулах хоолойн нийт 1.122 тэрбум ам.долларын санхүүжилтийг Эрдэнэс Тавантолгой ХК-д хариуцуулсан нь байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, засаглалын зарчим болон хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчиж, холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцэхгүй шийдвэр гаргасан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Богдхан төмөр зам төсөл – 734.6 сая ам.долларын санхүүжилт Засгийн газрын 2021 оны 206 дугаар тогтоолоор компанид зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын нийт санхүүжилтийг хариуцуулсан, Үүний дагуу байгуулсан МН-ЭТТ-2022/487, ТТЗ-МН22/01, ВI-BBR-CONT-0002 дугаар гэрээнүүдээр нийт 734.6 сая ам.долларын үүрэг хүлээж 130.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. 	1	1,042,697.8	1	1,042,697.8			

	<p>2. Газрын тос дамжуулах хоолойн төсөл – 388.0 сая ам.долларын санхүүжилт УУХУЯ-ны олон улсын нээлттэй тендерийн үр дүнд БНХАУ-ын төрийн өмчит “Норинко Интернэшнл Кооперэйшн” компани ЕРС гүйцэтгэгчээр сонгогдож, санхүүжилтийн 388.0 сая ам.долларыг ЭТТ ХК дангаар хариуцах зохицуулалт хийгдэж 919.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.</p> <p>3. Илрүүлэлтийн мөн чанар</p> <p>3.1. Компанийн засаглал, хөрөнгө оруулалтын бодлогыг зөрчсөн байдал Компанийн хөрөнгийг үндсэн чиг үүргээс гадуурх төслүүдэд чиглүүлсэн нь хувьцаа эзэмшигчдийн өмчийн эрхийг хязгаарласан, төрийн өмчит компанийн сахилга бат алдагдсан байдалтай байна.</p> <p>3.2. Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд нийцэхгүй Компанийн мөнгөн урсгал, өрийн дарамт, хөрвөх чадвар, үндсэн хөрөнгө оруулалтын бацад дарамт бий болно.</p> <p>3.3. Төсвийн бус эх үүсвэрийг ашиглан төрийн төсөл санхүүжүүлж буй зохицуулалтын эрсдэл</p> <p>Төсвийн ил тод байдал, өрийн удирдлагын зарчимтай зөрчилдөх, ашигт малтмалын орлогоор төсвийн бус төслийг санхүүжүүлсэн байдал бий болсон.</p>									
3	<p>Монгол Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар “Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай” тогтоолоор “Тавантолгой түлш” ХХК-ийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэхдээ хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх үүргийг Засгийн газарт үүрэг болгосон бөгөөд Засгийн газрын 2025 оны 18 дугаар тогтоолоор өр, авлагыг шийдвэрлэх үүргийг Эрдэнэс Тавантолгой ХК-д үүрэг болгосон боловч Тавантолгой түлш ХХК-ийн 1,366,306.1 сая өр төлбөр, 2,154.5 сая төгрөгийн авлагыг эцэслэн шийдвэрлээгүй байна.</p>	1	1,368,460.7	1	1,368,460.7					
4	<p>Компанийн энгийн хувьцааны 26.4 хувийг эзэмшигч Монгол Улсын иргэдийн хувьд нас баралт, харьяаллын өөрчлөлт, өв залгамжлалтай холбоотойгоор хувьцааны шилжилт, эрхийн хэрэгжилтийг хэрхэн зохицуулах талаарх эрх зүйн нарийвчилсан зохицуулалтгүй байна. Өмчлөх эрхийн ийм тодорхой бус байдал болон данс байхгүй холбоо тогтоох боломжгүй байдал зэрэг нь ногдол ашиг тараах үйл явцад шууд нөлөөлж 2019–2024 онд зарласан ногдол ашгаас давхардсан тоогоор 1,286,217 иргэн, 1,254 аж ахуйн нэгжид хамаарах нийт 145,205.4 сая төгрөг өнөөг хүртэл тараагдалгүй Сангийн яамны Төрийн сангийн дансанд байршиж байна.</p>	1	145,205.5	1	145,205.5					
5	<p>Нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-д хаягдлын далан байгуулахаар төлөвлөсөн боловч газрын ашиглалтын зөвшөөрөл олгогдоогүйгээс шалтгаалан уг байгууламжийг бариагүй, мөн зүгшрүүлэг тохирууллын ажлууд хийгдэж байгаатай холбоотойгоор бүрэн хүчин чадлаар ажиллаагүйгээс нэмэлт зардал гарсан байна. Тухайлбал:</p> <p>-2025 онд зүгшрүүлэх, тохируулах үйл ажиллагаа явагдсан ба 1,593.9 мянган тонн тэжээл хүлээн авч, үйлдвэрийн конвейрийн жингээр 1,166.8 мянган тонн</p>	1	-	-	-	1	-			

	<p>баяжмал, 345,378 тн хаягдал үйлдвэрлэсэн байна. Тус хаягдлыг Цанхийн зүүн уурхайн хөрсний 2-р овоолго руу зөөж нэмэлт зардал гаргаж байна. -Цахилгааны хэрэглээ нь ТЭЗҮ-д заасан утгаас хэлбэлзэлтэй байна. /1 тн бүтээгдэхүүнд зарцуулах ЦЭХ-ний хэрэглээ 7.05 квт/ц-аар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 9.47 квт/ц зарцуулсан/.</p>									
6	<p>Эрдэнэс Тавантолгой ХК нь уурхайн үйл ажиллагааны явцад үүсдэг хоёрдогч түүхий эд болох ашиглалтаас гарсан дугуй, кабель, зэс эд анги, металл хаягдал, тос, тосолгооны материал, багаж, эд ангилуудын ашиглах боломжтой хэсэг зэрэг эд хөрөнгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, үнэлэх, борлуулж орлого бүртгэх талаар зохицуулсан дотоод журам, бодлого байхгүй байна. Эдгээр бараа, материалын менежмент системтэй явагдаагүй, зарлага гаргаж компаниудад нийлүүлдэг, борлуулалтын боломжийг компанийн орлого болгон ашиглаагүй байна.</p>	1	-	1	-					
7	<p>Төв болон салбарын бүтэц зохион байгуулалт, чиг үүргийн уялдааг шалгахад компанийн засаглал, дотоод хяналт, төлөвлөлт ба гүйцэтгэлийн удирдлагад тавигдах хууль, дотоод журмын шаардлага хангагдаагүй, чиг үүргийн зааглал, хяналтын механизм, орон тооны зохицуулалт нь нэгдмэл байдлаа алдаж, байгууллагын үйл ажиллагаа хэсэгчилсэн, давхардсан бүтэцтэй болсон байна. Ийм нөхцөл байдал нь шийдвэр гаргалт, тайлагнал, хяналт-шинжилгээ болон үйл ажиллагааны нийт үр ашигт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Чиг үүргийн давхардал их, бүтэц системийн хувьд хэт задралтай байна Шинжилгээгээр хяналт-аудит-эрсдэлийн чиглэлийн 6 хүртэл нэгж зэрэглэн ажиллаж, тээвэр-логистик-ачилт-экспортын чиглэлд төв болон салбарын түвшинд дөрвөн өөр удирдлагын төв зэрэглэн оршиж буй нь байгууллагын гол үйл ажиллагаанд зохион байгуулалтын хүндрэл, давхардсан ачаалал бий болгож, мэдээллийн зөрүү, хэт төвлөрсөн зардал, хяналтын цоорхойг нэмэгдүүлж байна. Мөн стратеги-төлөвлөлт-төсөл боловсруулах чиг үүрэг салбарын инженерийн нэгжүүдтэй уялдаагүй, хоёр түвшний параллель төлөвлөлт үүссэн нь төсөл хэрэгжилтийн хугацаа алдагдах, өртөг өсөх шалтгаан болж байна. 2. Хяналтын тогтолцоо олон төвтэй, COSO-гийн зарчим алдагдсан байна COSO-ийн хяналтын загвараар дотоод хяналт нэг төвтэй, нэгдмэл удирдлагатай байх шаардлагатай. Гэтэл компанид хяналтын чиглэл дараах нэгжид тарамдсан байна. Үүнд: Дотоод аудитын алба, Дотоод хяналтын нэгж, Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэсэг, Эрсдэлийн удирдлагын нэгж, Салбарын хяналтын инженерүүд. <p>Эдгээр нэгжүүдийн хооронд уялдаа холбоо сул, чиг үүргийн зааг тодорхойгүй байгаа нь компанийн хяналтын тогтолцоог нэгдмэл, төвлөрсөн байдлаа алдуулж, үйл ажиллагаа нь жижиг хэсгүүдэд хуваагдан, харилцан уялдаагүй,</p>	1	-	-	1	-				

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	<p>үйл ажиллагаа байгууллагын тасралтгүй ажиллагааны шаардлагыг хангахгүй байна.</p> <p>Үүсэх эрсдэл: -Мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмж алдагдах бодит эрсдэлтэй. -Хорлонтой програм, халдлага илрэхгүй үлдэх, системийн эвдрэл бизнесийн тасалдахад хүрэх боломжтой. -Эрх бүхий хандалтын хяналтгүй байдлаас шалтгаалан дотоод болон гадаад халдлага өргөжин тэлэх эрсдэл өндөр.</p>									
12	<p>Үйлдвэрлэлийн болон хөгжүүлэлтийн орчинд ашиглагдаж буй сервер, өгөгдлийн сан болон аппликейшнүүд хуучирсан, дэмжлэггүй хувилбартай (Windows Server 2008 R2, SMBv1 идэвхтэй, SQL Server 2012 RTM) ажиллаж байгаа нь олон улсын CVE мэдээллийн сангаас өндөр эрсдэлтэй ангилагдсан эмзэг байдлуудад өртөх нөхцөл бүрдүүлж байна. Вэб аппликейшнүүдийн хандалтын хяналт хангалтгүй, security header-ууд (CSP, HSTS, X-Frame-Options, X-Content-Type-Options) бүрэн хэрэгжээгүй, файл upload хамгаалалтын шалгуур сул байна.</p>	1	-				1	-		
13	<p>Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг шинээр сонгон шалгаруулахдаа Төрийн өмч, бодлого зохицуулалтын газрын цахим хуудсаар олон нийтэд зарлан мэдээлээгүй байна.</p>	1	-				1	-		
14	<p>Компанийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, мөнгөн урсгалын төлөв байдлыг иж бүрэн үнэлж шийдвэрлээгүй байхад Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2024 оны олсон ашгаас иргэдэд ногдол ашиг хуваарилах асуудлыг Монгол Улсын Засгийн газар-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 225 дугаар тогтоолоор шийдвэрлэж, компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны гүйцэтгэлд үндэслэн 2024 оны цэвэр ашгийн зохих хувийг хуульд заасны дагуу ногдол ашиг хэлбэрээр иргэдэд хуваарилах арга хэмжээ авахыг даалгасан байна.</p> <p>Уг тогтоолыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Ногдол ашиг хуваарилах тухай” 03 дугаар тогтоолоор нэгж хувьцаанд 326.5 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар /терд 2,879.8 тэрбум төгрөг, аж ахуйн нэгжид 2.3 тэрбум төгрөг, иргэдэд 1,035.9 тэрбум төгрөг/ шийдвэрлэсэн нь компанийн санхүүгийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын эх үүсвэр болон мөнгөн урсгалын удирдлагад эрсдэл үүсгэхүйц өндөр түвшинд тогтоогдсон байна.</p>	1	-				1	-		
15	<p>“Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны Б/94, Б/96, Б/124 дүгээр тушаалаар Хяналтын менежер, Бүтээмжийн менежер, Бизнес хөгжил хариуцсан менежерийн албан тушаалуудыг шинээр бий болгож, эдгээрийн үндсэн цалинг компанийн цалингийн шатлалын G7-G8 түвшинд (12.5-14.0 сая төгрөг) тогтоон тайлант онд нийт 624.3 сая төгрөгийн цалин хөлс олгосон байна.</p>	1	624.4	1	624.4				624.4	

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	<p>Гэвч дээрх албан тушаалуудад тавигдах ажлын байрны шаардлага, үндсэн зорилго, чиг үүрэг, гүйцэтгэлийн хариуцлагын хүрээ бүрэн тодорхойлогдоогүй, байгууллагын бүтэц дэх байр суурь, эрх-хариуцлагын уялдаа тогтоогоогүй байхад томилгоо хийгдсэн байна.</p> <p>Мөн Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн багийн ажлагчийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/352 дугаар тушаалаар төв оффисын ажлын байрны нэршил, орон тоог шинэчлэн баталсан боловч дээрх албан тушаалуудын чиг үүрэг, хариуцлагын хуваарилалтыг нэг мөр тодорхой болгож чадаагүй байна." зөрчилд өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.</p> <p>Түүнчлэн Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 27 дугаар хуралдааны тэмдэглэлээр дээрх албан тушаалд ажиллаж байгаа менежерүүдийг цомхотгохыг чиглэл болгосон боловч хэрэгжүүлээгүй байна</p>							
	Нийт дүн	15	3,475,010.3	6	3,475,010.3	9	-	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 711/АД/16.0056

Улаанбаатар хот

САГ-2026/98/НА -СТА -ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Эрдэнэс Тавантолгой" ХК нь банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэсгүй боловч Засгийн газрын шийдвэрээр Багануур ХК, Шивээ-Овоо ХК, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, Тавантолгой төмөр зам ХХК, Монголын төмөр зам ТӨХК-уудад урт хугацаатай зээл олгож, нийт 918,021,916,664.00 /Есөн зуун арван найман тэрбум хорин нэгэн сая есөн зуун арван зургаан мянга зургаан зуун жаран дөрвөн/ төгрөгийн эргэн төлөлтийн эрсдэлтэй зээлийн авлага үүсгэсэн нь компанийн үйл ажиллагааны чиглэл, хууль эрх зүйн зохицуулалт, санхүүгийг сахилга бат болон засаглалын зарчимд үл нийцсэн, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчсөн байна. Тухайлбал:

1. Компанийн санхүүгийн тогтвортой байдалд өндөр эрсдэл бий болгосон

Эрх зүйн үндэсгүй олгосон зээлийн багц нь эртэн төлөлтийн эрсдэл өндөртэй, компанийн мөнгөн урсгалыг хумих, үндсэн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг хойшлуулах, балансын бүтэц, өрийн дарамтыг хүндрүүлэх сөрөг үр дагавар үүсгэж, компанийн санхүүгийн тогтвортой байдалд ноцтой эрсдэл бий болгосон.

2. Хувьцаа эзэмшигчдийн өмчийн эрхийг зөрчсөн байдал

Зээл олголт нь компанийн үндсэн зорилго, бизнесийн үйл ажиллагаанд хамааралгүй бөгөөд 3 сая хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг бууруулах, хөрөнгө оруулалтын боломжийг хязгаарлаж эрсдэлийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх зэрэг байдлаар хувьцаа эзэмшигчдийн өмчийн эрхийг зөрчсөн байна.

Энэ нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "банк бус санхүүгийн үйл ажиллагаа" гэж Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн эрхэлж байгаа энэ хуулийн 7.1.-д заасан үйлчилгээг", 6 дугаар зүйлийн 6.1-т "Банк бус санхүүгийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд эрхэлж болно", 7 дугаар зүйлийн 7.1.1-д "зээл" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316\SAG-36.Docx

1526180862

Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд нийцээгүй урт хугацаат зээлийг олгосноос үүдэн эргэн төлөлтийн эрсдэл бүхий зээлийн авлага үүсгэж байгаа тул зээл олгодог үйл ажиллагааг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ц.Нацагдорж/, Эрдэнэс тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Н.Цэрэнсамбуу/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга /Г.Гантулга/, Ерөнхий нягтлан бодогч /Ш.Цогзолмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
А.ДАВААДОРЖ
М.ГАНБААТАР
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 712/АД160056

Улаанбаатар хот

САГ-2026/98/КА-СТА-ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн үндсэн чиг үүргээс гадуурх улс орны стратегийн дэд бүтцийн томоохон төслүүд болох Богдхан төмөр зам болон газрын тос дамжуулах хоолойн нийт 1,122.6 тэрбум ам.долларын буюу 1,049,957,175,676.00 /Нэг их наяд дөчин есөн тэрбум есөн зуун тавин долоон сая нэг зуун далан таван мянга зургаан зуун далан зургаан/ төгрөгийн санхүүжилтийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-д хариуцуулсан нь байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, засаглалын зарчим болон хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчиж, холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцэхгүй шийдвэр гаргасан байна. Үүнд:

1. Богдхан төмөр зам төсөл – 734.6 сая ам.долларын санхүүжилт

Засгийн газрын 2021 оны 206 дугаар тогтоолоор компанид зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын нийт санхүүжилтийг хариуцуулсан. Үүний дагуу байгуулсан МН-ЭТТ-2022/487, ТТЗ-МН22/01, ВІ-ВВR-CONT-0002 дугаар гэрээнүүдээр нийт 734.6 сая ам.долларын үүрэг хүлээж 130.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

2. Газрын тос дамжуулах хоолойн төсөл – 388.0 сая ам.долларын санхүүжилт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны болон улсын нээлттэй тендерийн үр дүнд БНХАУ-ын төрийн өмчит "Норинко Интернашнл Кооперэйшн" компани ЕРС гүйцэтгэгчээр сонгогдож, санхүүжилтийн 388.0 сая ам.долларыг ЭТТ ХК дангаар хариуцах зохицуулалт хийгдэж 919.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

3. Илрүүлэлтийн мөн чанар

3.1. Компанийн засаглал, хөрөнгө оруулалтын бодлогыг зөрчсөн байдал

Компанийн хөрөнгийг үндсэн чиг үүргээс гадуурх төслүүдэд чиглүүлсэн нь хувьцаа эзэмшигчдийн өмчийн эрхийг хязгаарласан, төрийн өмчит компанийн сахилга бат алдагдсан байдалтай байна.

3.2. Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд нийцэхгүй

Компанийн мөнгөн урсгал, өрийн дарамт, хөрвөх чадвар, үндсэн хөрөнгө оруулалтын бацад дарамт бий болно.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-36.Docx

1526180908

3.3. Төсвийн бус эх үүсвэрийг ашиглан төрийн төсөл санхүүжүүлж буй зохицуулалтын эрсдэл

Төсвийн ил тод байдал, өрийн удирдлагын зарчимтай зөрчилдөх, ашигт малтмалын орлогоор төсвийн бус төслийг санхүүжүүлсэн байдал бий болсон байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах" гэж заасныг, 21 дүгээр зүйлийн 21-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн үндсэн чиг үүргээс гадуурх нийгмийн шинж чанартай төслийг санхүүжүүлж, байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, засаглалын зарчим болон хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчиж, холбогдох хууль, эрх зүйн шаардлагад нийцэхгүй шийдвэр гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс тавантолгой ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Нацагдорж, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Н.Цэрэнсамбуу/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга /Г.Гантулга/, Ерөнхий нягтлан бодогч /Ш.Цогзолмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
А.ДАВААДОРЖ
М.ГАНБААТАР
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 713/А0160056

Улаанбаатар хот

САГ-2026/98/НА-СТА-ТВҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай 10 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эрх бүхий байгууллага ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан тохиолдолд төрийн өмчид ногдох ногдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний нэгдэлд хамаарах, төрийн өмчийн оролцоотой бусад аж ахуйн нэгжүүдийн хооронд үүссэн өр, авлагыг суутган тооцохоор зохицуулсан. Гэвч энэхүү зохицуулалт бодитоор хэрэгжээгүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу 2022–2023 оны төрд ногдох ногдол ашгийн 3,305,196,752,456.00 /Гурван их наяд гурван зуун таван тэрбум нэг зуун ерэн зургаан сая долоон зуун тавин хоёр мянга дөрвөн зуун тавин зургаан/ төгрөгийн урт хугацаат өр төлбөр санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

Энэ нь УИХ-ын 2024 оны 10 дугаар тогтоолын 3-д “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн эрх бүхий этгээд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компани, түүний нэгдлийн болон бусад төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хооронд үүссэн өр авлагад суутган тооцох” заалтуудыг биелүүлээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс тавантолгой ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Нацагдорж, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Н.Цэрэнсамбуу/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга /Г.Гантулга/, Ерөнхий нягтлан бодогч /Ш.Цогзолмаа / нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
А.ДАВААДОРЖ
М.ГАНБААТАР
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 714/АД16005 6

Улаанбаатар хот

САГ-2026/98/КА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн энгийн хувьцааны 26.4 хувийг эзэмшигч Монгол Улсын иргэдийн хувьд нас баралт, харьяаллын өөрчлөлт, өв залгамжлалтай холбоотойгоор хувьцааны шилжилт, эрхийн хэрэгжилтийг хэрхэн зохицуулах талаарх эрх зүйн нарийвчилсан зохицуулалтгүй, эрх бүхий байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна. Өмчлөх эрхийн ийм тодорхой бус байдал нь ногдол ашиг тараах үйл явцад шууд нөлөөлж 2019–2024 онд зарласан ногдол ашгаас давхардсан тоогоор 1,286,217 иргэн, 1,254 аж ахуйн нэгжид хамаарах нийт 145,205,458,270.00 /Нэг зуун дөчин таван тэрбум хоёр зуун таван сая дөрвөн зуун тавин найман мянга хоёр зуун далан/ төгрөг өнөөг хүртэл тараагдалгүй Сангийн яамны Төрийн сангийн дансанд байршиж байна. Компанийн санхүүгийн тайланд өр төлбөр тусгасан зүйлгүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.13-т “Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани ахувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.” гэж заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 5795 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн энгийн хувьцааны 26.4 хувийг эзэмшигч Монгол Улсын иргэдийн хувьд нас баралт, харьяаллын өөрчлөлт, өв залгамжлалтай холбоотойгоор хувьцааны шилжилт, эрхийн хэрэгжилт, бүртгэлийн асуудлыг хэрхэн зохицуулах талаарх эрх зүйн нарийвчилсан зохицуулалттай болох саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлээгүй зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс тавантолгой ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Нацагдорж, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Н.Цэрэнсамбуу/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга /Г.Гантулга/, Ерөнхий нягтлан бодогч /Ш.Цогзолмаа / нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
А.ДАВААДОРЖ
М.ГАНБААТАР
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 715/А0160056

Улаанбаатар хот

САГ-2026/98/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс тавантолгой ХК нь уурхайн үйл ажиллагааны явцад үүсдэг хоёрдогч түүхий эд болох ашиглалтаас гарсан дугуй, кабель, зэс эд анги, металл хаягдал, тос, тосолгооны материал, багаж, эд ангиудын ашиглах боломжтой хэсэг зэрэг эд хөрөнгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, үнэлэх, борлуулж орлого бүртгэх талаар зохицуулсан дотоод журам, бодлого байхгүй байна. Эдгээр бараа, материалын менежмент системтэй явагдаагүй, зарлага гаргаж компаниудад нийлүүлсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 495 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Уурхайн үйл ажиллагааны явцад үүсдэг хоёрдогч түүхий эд болох ашиглалтаас гарсан дугуй, кабель, зэс эд анги, металл хаягдал, тос, тосолгооны материал, багаж, эд ангиудын ашиглах боломжтой хэсэг зэрэг эд хөрөнгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, үнэлэх, борлуулж орлого бүртгэх талаар зохицуулсан дотоод журам, бодлого байхгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс тавантолгой ХК-ний гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Н.Цэрэнсамбуу/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга /Г.Гантулга/, Ерөнхий нягтлан бодогч /Ш.Цогзолмаа / нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
А.ДАВААДОРЖ
М.ГАНБААТАР
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 716/АД160056

Улаанбаатар хот

САГ-2026/98/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар "Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай" тогтоолоор "Тавантолгой түлш" ХХК-ийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэхдээ хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх үүргийг Засгийн газарт үүрэг болгосон бөгөөд Засгийн газрын 2025 оны 18 дугаар тогтоолоор өр, авлагыг шийдвэрлэх үүргийг "Эрдэнэс тавантолгой" ХК-д үүрэг болгосон боловч Тавантолгой түлш ХХК-ийн 1,366,306,178.023.00 /Нэг их наяд гурван зуун жаран зургаан тэрбум гурван зуун зургаан сая нэг зуун далан найман мянга хорин гурван/ төгрөгийн өр төлбөр, 2,154,517,467.00 /Хоёр тэрбум нэг зуун тавин дөрвөн сая таван зуун арван долоон мянга дөрвөн зуун жаран долоон/ төгрөгийн авлагыг эцэслэн шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-т "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 18 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z: Alban Shaardlaga 2026/0316.SAG-36.Docx

1526180918

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс тавантолгой ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ц.Нацагдорж/, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Н.Цэрэнсамбуу/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга /Г.Гантулга/, Ерөнхий нягтлан бодогч /Ш.Цогзолмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Handwritten signatures and initials in black ink, including a large signature at the top right, a signature in the middle, and initials 'М.Ф.' at the bottom left.

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
А.ДАВААДОРЖ
М.ГАНБААТАР
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 717/АД160056

Улаанбаатар хот

САГ-2026/98/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Эрдэнэс Тавантолгой ХК-аас хэрэгжүүлж буй “Сая тонн – Сая мод” хөтөлбөрийн дагуу батлагдсан ТЭЗҮ-ийн үндсэн дээр улс, орон нутгийн хэмжээнд мод үржүүлгийн газар байгуулах, мод бут тарих, арчлан ургуулах зорилгоор Онцгой байдлын ерөнхий газартай 2022 онд байгуулсан ЭТТ-2022/503 дугаар бүхий “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 27,500,000,000.0 /хотин долоон тэрбум таван зуун сая/ төгрөгийг санхүүжүүлсэн боловч гэрээний үр дүнг дүгнээгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооцлого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-д “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 211 дүгээр зүйлийн 211.1-д “Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүрээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлалгүй”, 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үлдэслэн **ШААРДАХ нь:**

1. Онцгой байдлын ерөнхий газартай 2022 онд байгуулсан ЭТТ-2022/503 дугаар бүхий “Хамтран ажиллах гэрээ”-ний үр дүнг дүгнээгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230


Z: \Alban Shaurdlaga\2026\0316 SAG-36.Docx

1526180920

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс тавантолгой ХК-ний гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Н.Цэрэнсамбуу/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга /Г.Гантулга/, Ерөнхий нягтлан бодогч /Ш.Цогзолмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
А.ДАВААДОРЖ
М.ГАНБААТАР
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 718/A0160056

Улаанбаатар хот

САГ - 2026 /98/ИА -СТА -ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар "Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны Б/94, Б/96, Б/124 дүгээр тушаалаар Хяналтын менежер, Бүтээмжийн менежер, Бизнес хөгжил хариуцсан менежерийн албан тушаалуудыг шинээр бий болгож, эдгээрийн үндсэн цалинг компанийн цалингийн шатлалын G7-G8 түвшинд (12.5-14.0 сая төгрөг) тогтоон тайлант онд нийт 624,358,873.00 /зургаан зуун хорин дөрвөн сая гурван зуун тавин найман мянга найман зуун далан гурван/ төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Гэвч дээрх албан тушаалуудад тавигдах ажлын байрны шаардлага, үндсэн зорилго, чиг үүрэг, гүйцэтгэлийн хариуцлагын хүрээ бүрэн тодорхойлогдоогүй, байгууллагын бүтэц дэх байр суурь, эрх-хариуцлагын уялдаа тогтоогдоогүй байхад томилгоо хийгдсэн байна.

Мөн Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн багийн ахлагчийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/352 дугаар тушаалаар төв оффисын ажлын байрны нэршил, орон тоог шинэчлэн баталсан боловч дээрх албан тушаалуудын чиг үүрэг, хариуцлагын хуваарилалтыг нэг мөр тодорхой болгож чадаагүй байна." зөрчилд өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Түүнчлэн Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 27 дугаар хуралдааны тэмдэглэлээр дээрх албан тушаалд ажиллаж байгаа менежерүүдийг цомхотгохыг чиглэл болгосон боловч хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т "Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно", 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.2.чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох"; гэсэнтэй нийцэхгүй байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-201230


Z: Alban Shaardlaga 2026/0316 SAG-36.Docx

1526180916

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага болон Засгийн газрын хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс тавантолгой ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Нацагдорж, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Н.Цэрэнсамбуу/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга /Г.Гантулга/, Ерөнхий нягтлан бодогч /Ш.Цогзолмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
А.ДАВААДОРЖ
М.ГАНБААТАР
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 719/АД160056

Улаанбаатар хот

САГ-2026/98/НА - СТА - ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагаас бэлтгэн нийлүүлэгчидтэй байгуулсан зарим гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул байгаагаас гэрээний хугацаа хэтэрсэн, нийлүүлэх бараа материалыг хүлээн аваагүй, ажил үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэж гэрээг хаагаагүй зөрчил илэрч байна. Тухайлбал:

- “Хуа Еэ Интернэйшнл” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/300 тоот XCMG-XDE240 автосамосвалын сэлбэг эд анги нийлүүлэх гэрээний хэрэгжилт 97–235 хоногоор хоцорч, 383.1 сая төгрөгийн нийлүүлэлт хийгдээгүй;
- “Хьюндэй Автос” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/254 тоот XCMG XDE130 автосамосвалын сэлбэг эд анги нийлүүлэх гэрээний 3.7 сая төгрөгийн бараа материалыг хүлээн аваагүй;
- “Элит Рийч Зи Зи Ай” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/616 тоот XCMG XDE130 автосамосвалын сэлбэг эд анги нийлүүлэх гэрээний 5,303.3 сая төгрөгийн бараа материалыг хүлээн аваагүй;
- “Арбэл Алтай” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/313, ЭТТ-2025/313-01 тоот Цанхийн баруун уурхайн хөрсний 1, 2 дугаар овоолго дээрх дахин дамжуулах станцын гадна цахилгаан хангамжийн зураг төсөл боловсруулах гэрээний нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 18.7 сая төгрөгийн ажил үйлчилгээ хугацаа хэтэрсэн;
- “Зууны хөгжлийн зам” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/458 тоот 8.2 км авто замд байрлах нүхэн гарцын ухмалын хажуу налуугийн бэхэлгээний зураг төсөл боловсруулах 19.4 сая төгрөгийн ажил үйлчилгээ хугацаа хэтэрсэн;
- “Голомт өргөө” ХХК-тай байгуулсан ЭТТ-2020/189 тоот уурхайн ажилчдын хотхоны барилгын ажлын явцад зураг төсөл зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний гэрээний 77.5 сая төгрөгийн ажил үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэж, гэрээг хаагаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах.”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-36.Doux

1526180922


дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Бэлтгэн нийлүүлэгчидтэй байгуулсан зарим гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул байгаагаас гэрээний хугацаа хэтэрсэн, нийлүүлэх бараа материалыг хүлээн аваагүй, ажил үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэж гэрээг хаагаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс тавантолгой ХК-ний гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Н.Цэрэнсамбуу/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга /Г.Гантулга/, Ерөнхий нягтлан бодогч /Ш.Цогзолмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Handwritten signatures of the officials listed to the right.

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
А.ДАВААДОРЖ
М.ГАНБААТАР
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ

